

# 1996 ОНЫ МАЛ ТООЛЛОГО

## ОРШИЛ

Манай улсын дотоодын нийт бүтээгдэхүүн 1996 онд 1995 онтой харьцуулахад 2.6 хувь өсөх төлөвтэй байна. Энэ өсөлт нь хөдөө аж ахуйн салбарын 2.0 хувь, барилгын салбарын 3.6 хувь, тээврийн салбарын 8.9 хувь, холбооны салбарын 8.8 хувь, худалдааны салбарын 1.1 хувийн өсөлтөөр хангагдаж байна.

Хөдөө аж ахуйн манай орны эдийн засгийн үндсэн гол салбарын нэг мөн. Тус салбарт 1996 оны байдлаар нийт ажиллагсадын 40 гаруй хувь ажиллаж, дотоодын нийт бүтээгдэхүүний 30 орчим хувийг үйлдвэрлэж, экспортын 25.7 хувь ногдож байна.

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн 80 гаруй хувийг эзэлдэг мал аж ахуйн салбарын хөгжил, түүний бүтээгдэхүүний өсөлтөөс улс орны эдийн засгийн бусад салбар ихээхэн шалтгаалдаг билээ. Нийт малын тоо 1996 оны эцэст 29.3 саяд хүрч, 1995 оныхоос 727.8 мянган толгойгоор өсчээ.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн ( хуучин нэрээр ) 1966 оны 398, Засгийн газрын 1991 оны 314 дүгээр тогтоолыг удирдлага болгон, Улсын статистикийн газраас батлаж гаргасан маягт, зааврын дагуу 1996 оны мал тооллогыг 12 дугаар сарын 15-22 ны хооронд зохион байгуулж явуулав. Тооллогоор манай улсын бүх мал сүрэг, тэжээвэр амьтад, хашаа, худаг, уст цэгийн тоо, малын тэжээлийн хэмжээг тооллогонд бүрэн хамруулж, дүн бүртгэлд тусгах, тооллогыг явуулахдаа нүдээр үзэж биечлэн тоолох зарчмыг мөрдлөгө болгох зорилт тавьсан болно.

1996 оны мал тооллого нь өмнөх жилүүдээс ялгагдах онцлогтой явагдав. Тооллоготой хамтруулан малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэн, орлогыг нь тодорхойлж, тэдний соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлттэй холбон судалгаа явуулсан юм.

Аймаг, сум, нийслэл, дүүрэгт мал тооллогыг удирдан зохион байгуулж явуулах комиссыг шинэчлэн байгуулж, нэгдсэн семинар зөвлөлгөөн төв, орон нутагт зохиогдон, ихэнх аймаг сумдадаа төлөөлөгч томилон ажиллуулсны зэрэгцээ тооллогын хяналт шалгалтыг боломжийнхоо хирээр явуулсан байна. Мал тооллого тогтоосон хугацаандаа явагдаж, дүнг аймаг, нийслэлийн засаг даргын өргөтгөсөн хуралд оруулан хэлэлцүүлж батлуулжээ.

Мал тооллогын ажил нийтдээ зохих заавар журмын дагуу явагдаж, дүн нь бодитой үнэн зөв гарсан гэж үндэстэй байна. Учир нь олон аймагт цаг хүндэрсэнтэй холбогдон малыг олноор нь нядалсныг эс тооцвол малын тоо хүлээгдэж байгаа гүйцэтгэлтэй үндсэндээ дүйж байгаа юм.

Мал тооллогын дүнг тооцоолох техник ашиглан боловсруулах талаар Дархан-Уул, Төв, Хөвсгөл зэрэг ихэнх аймгийн статистикийн албад идэвх зүтгэлтэй ажиллаж, тодорхой амжилтанд хүрчээ. Гэвч Булган, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотын статистикийн алба цэвэр, эрлийз малын тооллого болон бусад материалыг компьютерт боловсруулах ажлаар ихээхэн хоцорч байгаа нь ажиглагдав. Энэ нь уг ажлыг эрхэлж байгаа хүмүүсийн компьютер эзэмших

мэдлэг чадвар, нөгөөтэйгүүр статистикийн албаны боловсон хүчний тогтвор суурьшилтай шууд холбоотой байна.

Мал тооллогын ажлыг зохион байгуулах, тооллогын дүнгийн боловсруулалт, үнэн зөвийг хангах талаар нийслэлийн Засаг даргын тамгын газраас зориуд анхаарах шаардлагатай байна.

Хэнтий аймагт мал тооллогын эцэслэсэн дүнгээр урьдчилсан дүнгээс үхрийн тоо 3.0 мянгаар буурсан, Өвөрхангай аймагт малын орлого, зарлагын хөдөлгөөнийг хийхдээ зах зээлд худалдсан гэсэн үзүүлэлт нөхөөгүй зэрэг дутагдал гарсан байна.

Тооллогоор урьд нь улсад мэдээлж байсан бойжуулсан төлийн тоо Ховд, Баянхонгор аймагт 70-71 мянга, Улаанбаатар, Увс, Говь-Алтай аймагт 24-29 мянгаар буурч гарлаа. Ингэж төлийн хорогдол, бойжсон төлийн тоог тухай бүрд нь шинэчилж өгөхгүй, мэдээлэлийн үнэн зөв байдал хангагдахгүй байгаагаас 1996 оны 10-р сарын мэдээгээр 9.2 сая сая төл бойжиж байсан дүн, жилийн эцсийн тооллогоор 9.0 сая болж буурсан дүнтэй болов. Энэ нь мэдээ тайлангийн талаар хуулинд заасан үүрэг сум, орон нутагт хангалтгүй биелэгдэж байгаа баримт мөн. Багийн дарга нар айлуудаараа явдаггүй хэрнээ мэдээ гараад байх юм гэсэн зүй ёсны үндэслэлтэй шүүмжлэл гарч байгааг анхаарч мэдээллийн хамралт, үнэн зөвийг хангуулах ажлыг эрс сайжруулах шаардлагатай байна.

Улсын мэдээллийн үнэн зөвд хийх үзлэг шалгалт, мал тооллогын үеэр улсаас зориуд зохион байгуулж хийх хяналтын тооллого зордал мөнгөтэй холбогдон ойрын жилүүдэд хийгдсэнгүй.

Статистикийн мэдээний гаргалт, тооллогын ажлыг явуулах, дуунг боловсруулах талаар багийн засаг дарга нарын сургалтыг улс, аймгийн түвшинд онцгой анхаарч зохион байгуулах, тэдгээрийг шаардлагат тооцооны хэрэгслэлээр хангах нь чухал гэсэн саналууд орон нутгаас байнга тавьж байна.

Сүхбаатар, Өмнөговь зэрэг аймгаас мал тооллогыг намар 10 сард явуулах нь зүйтэй гэсэн санал гарсан байна. Айл өрх бөөн, мал билчээр усандаа ойрхон байдаг цагт тооллого явуулвал мал тооллогын чанарт сайнаар нөлөөлөхийн гадна ердийн хөсөг өргөн ашиглаж, машин техник, бензин шатахууны зардал эрс буурна гэж үзжээ. Энэ саналын хувьд үнэхээр ийм байх үндэстэй. 1961 өмнө мал тооллогыг намар, зун явуулж байсан билээ. Гэвч малыг намар тоолох, өвөл жилийн эцэст тоолохын аль алинд нь өөрийн даавуу болон сул талууд байгаа юм.

Жилийн эцэст тоолохын давуутай тал нь гэвэл хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын зарлага бүрэн гарсан байдаг тул дүнг өмнөх жилүүдтэй шууд зэрэгцүүлэх боломжтой зэрэг сайн талууд байхад өвлийн хүйтэнд тооллогын чанар муу явагддаг, зардал нэмэгддэг нь үнэн юм. Иймээс уг асуудлыг аймаг, орон нутгийн саналыг бүрэн авсны үндсэн дээр судлаж, хэрэв хугацааг өөрчлөх бол Сайд нарын Зөвлөлийн 1966 оны 398 дугаар тогтоолын заалтыг өөрчлөх шийдвэрийг Засгийн газарт оруулах шаардлагатай болно.

## II. МАЛ ТЭЖЭЭВЭР АМЬТАДЫН ТОО, БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮН

### II.1. Малын тоо, бүрэлдэхүүн, тархалт.

**Нийт малын тоо.** 1996 оны эцэст 29.3 сая мал тоологдсон нь 1995 оныхоос 2.5 хувь буюу 727.8 мянган толгойгоор өссөний дотор ямаа 614.1 мянга, үхэр 159.2 мянга, адуу 122.1 мянгаар нэмэгдэж, харин тэмээ 9.6 мянга, хонь 158.0 мянгаар хорогдлоо.

Бодод шилжүүлснээр малын тоо урьд оныхоос 3.2 хувь буюу 317.4 мянгаар өссөн байна.

Малын тоо (мян.тол)

|             | 1992    | 1993    | 1994    | 1995    | 1996    | 1996/1995 |        |
|-------------|---------|---------|---------|---------|---------|-----------|--------|
|             |         |         |         |         |         | %         | Зөрүү  |
| Бодоор *    | 8785.3  | 8532.2  | 9166.2  | 9868.2  | 10185.6 | 104.9     | 497.6  |
| Толгойн тоо | 25694.1 | 25174.7 | 26808.1 | 28572.3 | 29300.1 | 106.8     | 1992.2 |
| Тэмээ       | 415.2   | 367.7   | 366.1   | 367.5   | 35557.9 | 99.3      | -2.5   |
| Адуу        | 2200.2  | 2190.3  | 2408.9  | 2648.4  | 2770.5  | 104.4     | 122.7  |
| Үхэр        | 2819.2  | 2730.5  | 3005.2  | 3317.1  | 3476.3  | 103.9     | 136.5  |
| Хонь        | 14657.0 | 13779.2 | 13786.6 | 13718.6 | 13560.6 | 104.5     | 605.0  |
| Ямаа        | 5602.5  | 6107.0  | 7541.3  | 8520.7  | 9134.8  | 112.4     | 1130.5 |

\* Бодод шилжүүлэхдээ адуу, үхрийг нэг бод, тэмээг 1.5 бод, 6 хонь, 8 ямааг тус бүр нэг бод гэж тооцов.

16 аймаг, Улаанбаатар хот урьд онд байсан малаа бодод шилжүүлснээр болон толгойн дүнгээр өсгөсний дотор Өмнөговь, Говьсүмбэр аймаг таван төрөл дээр нь өсгөв.

Сумдаас Дундговь аймгийн Мандалговь, Сэлэнгийн Алтанбулаг, Говьсүмбэрийн Баянтал, Төв аймгийн Сүмбэр, Өмнөговийн Манлай зэрэг 18 аймгийн 79 сум, Налайх дүүрэг малаа төрөл бүр дээр өсгөжээ.

Ховд, Орхон, Өвөрхангай, Дархан-Уул, Говь-Алтай аймгийн малын тоо 0.7 – 5.6 хувь буюу 1.5 – 115.7 мянган толгойгоор хорогдсон байна.

Тэмээн сүргийн тоо 18 аймагт, хонин сүргийн тоо 11 аймаг, хотод буулсны дотор хонь Говь-Алтай, Ховд, Өвөрхангай аймагт 50.0-89.5 мянга, Баянхонгор, Увс аймагт 25.1-34.8 мянга, тэмээ Говь-Алтай, Ховд аймагт 1.4-1.7 мянга, Өвөрхангай, Дорноговь, Дундговь, Баянхонгор аймагт 1.0-1.2 мянга, Увс аймагт 0.5 мянгаар цөөрчээ. ( Хавсралт хүснэгтийн 4.5-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана. )

Малын өсөлт, бууралтын хэмжээгээр аймгуудыг байр эзлүүлбэл :

|                | 1996\1996          |                 |                 |                 |
|----------------|--------------------|-----------------|-----------------|-----------------|
|                | Бодод шилжүүлснээр |                 | Толгойн тоогоор |                 |
|                | хувь               | Зөрүү (мян.бод) | Хувь            | Зөрүү (мян.тол) |
| 1.Говьсүмбэр   | 109.1              | 3.0             | 107.4           | 7.6             |
| 2.Дундговь     | 108.3              | 43.4            | 107.6           | 130.5           |
| 3.Архангай     | 107.7              | 55.7            | 106.1           | 98.7            |
| 4.Өмнөговь     | 107.1              | 27.6            | 109.8           | 117.4           |
| 5.Төв          | 106.6              | 44.1            | 105.7           | 101.5           |
| 6.Хөвсгөл      | 106.3              | 49.6            | 106.4           | 119.6           |
| 7.Булган       | 105.2              | 25.6            | 105.8           | 65.5            |
| 8.Баян-Өлгий   | 104.8              | 18.4            | 103.8           | 51.6            |
| 9.Хэнтий       | 104.4              | 20.1            | 104.5           | 49.5            |
| 10.Завхан      | 104.3              | 32.8            | 103.0           | 73.1            |
| 11.Дорноговь   | 104.3              | 13.8            | 104.1           | 36.3            |
| 12.Баянхонгор  | 102.4              | 15.4            | 100.3           | 5.9             |
| 13.Улаанбаатар | 101.2              | 1.5             | 103.9           | 11.5            |
| 14.Увс         | 100.7              | 4.0             | 100.6           | 10.7            |
| 15.Сүхбаатар   | 100.4              | 1.5             | 102.5           | 25.3            |
| 16.Орхон       | 100.1              | 0.0             | 96.7            | -4.2            |
| 17.Сэлэнгэ     | 100.0              | 0.0             | 100.4           | 1.9             |
| 18.Говь-Алтай  | 99.7               | -1.5            | 99.3            | -15.5           |
| 19.Дорнод      | 99.1               | -2.4            | 100.5           | 2.8             |
| 20.Өвөрхангай  | 98.3               | -14.9           | 98.3            | -44.8           |
| 21.Дархан-Уул  | 97.9               | -1.2            | 98.9            | -1.5            |
| 22.Ховд        | 96.8               | -19.2           | 94.4            | -115.7          |

Манай орны түүхэнд хамгийн олон мал, тэрчлэн адуу, үхэр, ямаа 1996 онд тоологдов.

Малын тоо толгойн хүрсэн дээд хэмжээг үзүүлбэл:

|       | 1918 оноос хойш |      | Жилийн эцэст тоолдог болсон<br>1961 оноос хойш |      |
|-------|-----------------|------|--|------|
|       | мян.тол         | он   | мян.тол  | он   |
| Бүгд  | 29300.1         | 1996 | 29300.1  | 1996 |
| Тэмээ | 895.3           | 1954 | 751.7  | 1961 |
| Адуу  | 2770.5          | 1996 | 2770.5   | 1996 |
| Үхэр  | 3476.3          | 1996 | 3476.3   | 1996 |
| Хонь  | 15936.4         | 1941 | 15083.0  | 1990 |
| Ямаа  | 9134.8          | 1996 | 9134.8   | 1996 |

1990 оноос хойш нийт сүрэгт тэмээ, хонины эзлэх хувийн жин жилээс жилд буурч байна.

Нийт сүрэгт таван төрлийн малын эзлэх хувь

|       | 1990 | 1991 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 |
|-------|------|------|------|------|------|------|------|
| Тэмээ | 2.1  | 1.9  | 1.6  | 1.5  | 1.4  | 1.3  | 1.2  |
| Адуу  | 8.8  | 8.8  | 8.6  | 8.7  | 9.0  | 9.3  | 9.4  |
| Үхэр  | 11.0 | 11.0 | 11.0 | 10.8 | 11.2 | 11.6 | 11.9 |
| Хонь  | 58.3 | 57.7 | 57.0 | 54.7 | 51.4 | 48.0 | 46.3 |
| Ямаа  | 19.8 | 20.6 | 21.8 | 24.3 | 27.0 | 29.8 | 31.2 |
| Бүгд  | 100  | 100  | 100  | 100  | 100  | 100  | 100  |

Улсад нийт малын тоогоор Өвөрхангай, тэмээгээр Өмнөговь, адуугаар Төв, үхрээр Хөвсгөл, хониор Завхан, ямаагаар Баянхонгор аймгууд тэргүүн байранд байна.

Манай улс дэлхийн улс орнуудын дотор адуугаар 6 дугаар, тэмээгээр 11, ямаагаар 15, хониор 23, үхрээр 57 дугаар байранд орж байна.

Ази тивд адуугаар 2 дугаар, тэмээгээр 3, хонь, ямаагаар тус бүр 8, үхрээр 15 дугаар байранд орж байна.

Адуу, тэмээний тоо, 1995 оны байдлаар ( мян.тол )

| Улсын нэр  | Адууны тоо | Улсын нэр     | Тэмээний тоо |
|------------|------------|---------------|--------------|
| 1.Хятад    | 10039      | 1.Сомали      | 6200         |
| 2.Мексик   | 6185       | 2.Судан       | 2903         |
| 3.Бразил   | 6300       | 3.Энэтхэг     | 1520         |
| 4.АНУ      | 6000       | 4.Пакистан    | 1119         |
| 5.Аргентин | 3300       | 5.Мавритан    | 1087         |
| 6.Монгол   | 2771       | 6.Этиоп       | 1000         |
|            |            | 7.Кени        | 810          |
|            |            | 8.Чад         | 600          |
|            |            | 9.Саудын араб | 418          |
|            |            | 10.Нигер      | 380          |
|            |            | 11.Монгол     | 358          |
|            |            |               |              |

Тайлбар: Монгол улсын малын тоог 1996 оны тооллогоор авсан болно. Манай улс, дэлхийд нэг хүн амд ногдох адуу, ямаагаар тэргүүн байр, тэмээ, хониор 4-р байранд тус, тус орж байна.

Нэг хүн амд ногдох малын тоогоор эхний байруудад ордог улс орнуудыг үзүүлбэл: ( толгой )

| Адуугаар          | Тэмээгээр    | Хониор           | Ямаагаар     |
|-------------------|--------------|------------------|--------------|
| 1. Монгол 1.2     | Сомали 0.7   | Шинэ Зеланд 13.2 | Монгол 3.9   |
| 2.Казахстан 0.1   | Мавритан 0.5 | Уругвай 7.1      | Мавритан 1.6 |
| 3.Аргентин 0.09   | Чад 0.18     | Австрали 6.8     | Сомали 1.4   |
| 4.Кыргызстан 0.07 | Монгол 0.15  | Монгол 5.8       | Мали 0.7     |
| 5.Мексик 0.06     | Судан 0.1    | Казахстан 2.0    | Судан 0.6    |

**Хувийн ( амины ) малын тоо.** 1996 онд улсын хэмжээгээр аминдаа малтай 278.3 мянган өрх тоологдсоны дотор 61.1 хувь буюу 170.1 мянга нь малчин

өрх, 38.9 хувь буюу 108.2 мянга нь мал бүхий бусад иргэдийн өрх байна. Хувийн малын тоо 1990 онд нийт малын 31.9 хувь байснаа 1996 онд 93.4 хувийг эзлэх болов. 1996 онд хувийн малын тоо 27.4 саяд хүрч, 1995 оныхоос 918.0 мянгаар нэмэгдэв.

Ямаа адууны 96.4-96.8 хувь , тэмээ, үхрийн 95.6-95.7 хувь, хонины 89.9 хувь нь хувийн аж ахуйд ногдох болжээ.

Ховд, Өвөрхангай, Говь-Алтайгаас бусад бүх аймаг, хотод хувийн малын тоо урьд оныхоос 0.4-13.3 хувиар өссөний дотор Хөвсгөл, Төв аймагт 132.3-134.5 мянга, Дундговь аймагт 129.2 мянга, Архангай, Өмнөговь аймагт 115.4-119.9 мянгаар нэмэгдэв.

Хувийн малын өсөлт, аймгаар (мян.тол)

|             | Толгойн тоо (мян.тол) |         |         |         |         | 1996\1995 |        |
|-------------|-----------------------|---------|---------|---------|---------|-----------|--------|
|             | 1992                  | 1993    | 1994    | 1995    | 1996    | Хувь      | Зөрүү  |
| Архангай    | 1317.6                | 1436.6  | 1570.2  | 1577.9  | 1697.8  | 107.6     | 119.9  |
| Баян-Өлгий  | 788.8                 | 975.5   | 1126.8  | 1324.6  | 1381.3  | 104.3     | 56.7   |
| Баянхонгор  | 1049.7                | 1623.6  | 1903.8  | 2134.8  | 2155.2  | 101.0     | 20.4   |
| Булган      | 590.6                 | 901.3   | 953.5   | 1018.6  | 1096.5  | 107.7     | 77.9   |
| Говь-Алтай  | 1156.3                | 1687.0  | 1911.5  | 2044.3  | 2038.7  | 99.7      | -5.6   |
| Дорноговь   | 516.9                 | 660.1   | 711.3   | 776.5   | 817.2   | 105.2     | 40.7   |
| Дорнод      | 526.5                 | 533.8   | 503.3   | 466.9   | 483.8   | 103.6     | 16.9   |
| Дундговь    | 1084.4                | 1429.2  | 1470.5  | 1660.8  | 1790.0  | 107.8     | 129.2  |
| Завхан      | 1400.9                | 1920.8  | 2176.2  | 2330.4  | 2408.3  | 103.3     | 77.9   |
| Өвөрхангай  | 1849.0                | 1997.6  | 2225.1  | 2465.3  | 2427.5  | 98.5      | -37.8  |
| Өмнөговь    | 744.7                 | 857.8   | 1001.0  | 1159.6  | 1275.0  | 110.0     | 115.4  |
| Сүхбаатар   | 761.9                 | 884.1   | 895.0   | 894.8   | 937.8   | 104.8     | 43.0   |
| Сэлэнгэ     | 263.4                 | 255.4   | 298.5   | 314.0   | 331.4   | 105.6     | 17.4   |
| Төв         | 1076.8                | 1231.4  | 1278.7  | 1420.8  | 1553.1  | 109.3     | 132.3  |
| Увс         | 1055.9                | 1509.7  | 1601.8  | 1657.0  | 1679.5  | 101.4     | 22.5   |
| Ховд        | 1195.1                | 1665.6  | 1771.6  | 1944.5  | 1842.3  | 94.7      | -102.2 |
| Хөвсгөл     | 1505.3                | 1576.6  | 1715.4  | 1789.1  | 1923.6  | 107.5     | 134.5  |
| Хэнтий      | 816.2                 | 1009.4  | 952.5   | 959.7   | 1004.4  | 104.7     | 44.7   |
| Дархан-Уул  | 88.5                  | 87.8    | 101.0   | 102.4   | 102.8   | 100.4     | 0.4    |
| Улаанбаатар | 202.2                 | 206.9   | 229.5   | 250.2   | 254.7   | 101.8     | 4.5    |
| Орхон       | 54.6                  | 71.5    | 81.3    | 95.4    | 96.7    | 101.4     | 1.3    |
| Говьсүмбэр  | 35.8                  | 43.5    | 48.7    | 59.6    | 67.6    | 113.4     | 8.0    |
| ДҮН         | 18081.1               | 22565.2 | 24527.2 | 26447.2 | 27365.2 | 103.5     | 918.0  |

Хувийн аж ахуйд байгаа малын бүтцийг авч үзвэл хонь 44.5 хувь, ямаа 32.3, үхэр 12.1, адуу 9.8, тэмээ 1.3 хувийг эзлэж байна.

Хувийн аж ахуйн мал, төрлөөр ( мян.тол )

|      | Малтай<br>өрхийн<br>тоо | Бүгд    | Ү Ү Н Э Э С |        |        |         |        |
|------|-------------------------|---------|-------------|--------|--------|---------|--------|
|      |                         |         | Тэмээ       | Адуу   | Үхэр   | Хонь    | Ямаа   |
| 1990 | 262.3                   | 8242.9  | 88.2        | 1108.1 | 1457.5 | 3684.7  | 1904.4 |
| 1991 | 288.9                   | 14002.6 | 186.3       | 1492.1 | 1896.6 | 7209.4  | 3218.2 |
| 1992 | 301.5                   | 18081.1 | 253.7       | 1728.0 | 2237.4 | 9589.1  | 4272.9 |
| 1993 | 289.7                   | 22565.2 | 335.0       | 2026.8 | 2503.5 | 11902.0 | 5797.9 |
| 1994 | 289.2                   | 24527.2 | 343.3       | 2279.0 | 2811.8 | 12133.8 | 6959.3 |
| 1995 | 283.9                   | 26447.2 | 349.7       | 2532.0 | 3140.4 | 12194.1 | 8231.0 |
| 1996 | 278.3                   | 27365.2 | 342.6       | 2670.6 | 3323.4 | 12184.6 | 8844.0 |

Иргэдийн хувийн малын бүлэглэлтээс үзвэл 51-100 малтангууд бусад бүлгээс харьцангуй олонхи нь байна.

1996 онд цөөн малтай ( 1-10, 11-30, 31-50 малтан ) өрхийн тоо, хувийн жин урьд оныхоос буурч, 51-100, түүнээс дээш малтай өрхийн тоо, хувийн жин бүлэг тус бүр дээр нэмэгдсэн байна.

Иргэдийн хувийн малын бүлэглэлт

|                      | Малтай өрхийн тоо |        | Дүнд эзлэх хувь |      | Малын тоо |         |
|----------------------|-------------------|--------|-----------------|------|-----------|---------|
|                      | 1995              | 1996   | 1995            | 1996 | 1995      | 1996    |
| 10хүртэл малтай      | 43694             | 39778  | 15.4            | 14.3 | 273.4     | 233.1   |
| 11-30 малтай         | 50580             | 47080  | 17.8            | 16.9 | 1048.0    | 969.0   |
| 31-50 малтай         | 40200             | 37462  | 14.2            | 13.5 | 1617.2    | 1517.6  |
| 51-100 малтай        | 61082             | 61464  | 21.5            | 22.1 | 4569.5    | 4524.7  |
| 101-200 малтай       | 53564             | 55383  | 18.9            | 19.9 | 7642.7    | 7838.5  |
| 201-500 малтай       | 31393             | 32983  | 11.0            | 11.8 | 9036.1    | 9410.5  |
| 501-999 малтай       | 3095              | 3678   | 1.1             | 1.3  | 1905.6    | 2298.3  |
| 1000-1499 малтай     | 280               | 445    | 0.1             | 0.2  | 309.8     | 496.8   |
| 1500-2000 малтай     | 17                | 32     | 0               | 0    | 27.8      | 53.2    |
| 2001-ээс дээш малтай | 8                 | 10     | 0               | 0    | 16.9      | 23.1    |
| ДҮН                  | 283913            | 278315 | 100             | 100  | 26447.0   | 27364.8 |

Улсын дунджаар малтай нэг өрхөд ( бодод шилжүүлснээр ) 35 бод буюу 93 толгой мал ногдож байхад Дундговь, Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Завхан аймагт 41-55 бод, 129-179 толгой мал ногдож байна.

Хувийн малтай нэг өрхөд ногдох хувийн малын тоо

|             | Бодод шилжүүлснээр |      |      | Толгойн тоогоор |      |      |
|-------------|--------------------|------|------|-----------------|------|------|
|             | 1994               | 1995 | 1996 | 1994            | 1995 | 1996 |
| Архангай    | 30.7               | 32.1 | 34.9 | 71              | 72   | 77   |
| Баян-Өлгий  | 22.9               | 26.1 | 27.2 | 80              | 92   | 95   |
| Баянхонгор  | 32.5               | 36.9 | 37.1 | 115             | 129  | 127  |
| Булган      | 32.8               | 39.5 | 41.0 | 75              | 89   | 93   |
| Говь-Алтай  | 38.5               | 41.1 | 41.1 | 154             | 162  | 162  |
| Дорноговь   | 43.3               | 45.1 | 47.7 | 117             | 122  | 129  |
| Дорнод      | 24.2               | 24.4 | 27.2 | 51              | 50   | 57   |
| Дундговь    | 44.8               | 51.8 | 55.3 | 146             | 169  | 179  |
| Завхан      | 35.8               | 39.2 | 41.9 | 114             | 122  | 129  |
| Өвөрхангай  | 31.2               | 35.4 | 35.5 | 94              | 105  | 105  |
| Өмнөговь    | 41.9               | 45.7 | 49.1 | 124             | 141  | 155  |
| Сүхбаатар   | 34.9               | 37.2 | 39.4 | 85              | 88   | 95   |
| Сэлэнгэ     | 10.3               | 11.8 | 12.9 | 24              | 27   | 30   |
| Төв         | 25.8               | 30.0 | 34.1 | 65              | 74   | 84   |
| Увс         | 26.6               | 28.6 | 29.9 | 84              | 88   | 93   |
| Ховд        | 34.6               | 38.3 | 38.0 | 119             | 131  | 127  |
| Хөвсгөл     | 30.4               | 33.3 | 35.8 | 73              | 78   | 83   |
| Хэнтий      | 31.9               | 34.5 | 37.1 | 74              | 78   | 84   |
| Дархан-Уул  | 8.4                | 9.3  | 10.4 | 20              | 21   | 24   |
| Улаанбаатар | 8.2                | 9.9  | 11.2 | 20              | 23   | 26   |
| Орхон       | 10.4               | 12.6 | 14.5 | 26              | 30   | 33   |
| Говьсүмбэр  | 16.4               | 19.9 | 22.3 | 41              | 52   | 58   |
| ДҮН         | 29.4               | 32.6 | 34.7 | 85              | 93   | 98   |

**Хээлтэгч мал.** 1996 оны эцэст 11771.8 мянган хээлтэгч мал тоологдсон нь урьд оныхоос 229.6 мянгаар өссөний дотор эм ямаа 268.9 мянга, гүү 29.9 мянга, үнээ 37.6 мянгаар өсч, эм хонь 104.2 мянга, ингэ 2.6 мянгаар буурсан байна.

Хээлтэгч малын тоо (мян.тол)

|         | 1992    | 1993    | 1994    | 1995    | 1996    | 1996\1995 |        |
|---------|---------|---------|---------|---------|---------|-----------|--------|
|         |         |         |         |         |         | Хувь      | Зөрүү  |
| Ингэ    | 112.2   | 99.2    | 100.8   | 101.3   | 98.7    | 97.4      | -2.6   |
| Гүү     | 566.0   | 580.2   | 650.3   | 707.1   | 737.0   | 104.2     | 29.9   |
| Үнээ    | 1032.2  | 1043.0  | 1170.6  | 1177.8  | 1215.4  | 103.2     | 37.6   |
| Эм хонь | 7098.8  | 6476.9  | 6320.1  | 5948.3  | 5844.1  | 98.2      | -104.2 |
| Эм ямаа | 2653.9  | 2880.4  | 3271.5  | 3607.7  | 3876.6  | 107.5     | 268.9  |
| ДҮН     | 11463.1 | 11079.7 | 11513.3 | 11542.2 | 11771.8 | 102.0     | 229.6  |

9 аймаг хээлтэгч малынхаа тоог урьд оныхоос бууруулсны дотор Говь-Алтай, Ховд аймаг 18.8-26.7 мянга, Сэлэнгэ, Дархан-Уул аймаг тус бүр 4.7 мянгаар хорогдуулжээ. (Хавсралтын хуудасны дугаар 14 – 16)



Бүх хээлтэгч малын 92.1 хувь нь хувийн, 7.9 нь аж ахуйн бусад хэвшилд хамрагдаж байгаагийн дотор ингэний 95.1, гүүний 96.4, үнээний 95.0, эм хонины 88.0, эм ямааны 96.5 хувь нь хувийн аж ахуйд байна. 1996 хамгийн олон үнээ, гүү, эм ямаа тоологдлоо.

1961 оноос хойш хамгийн олон хээлтэгч мал тоологдсон жил

|      | мян.тол | Он   |         | мян.тол | Он   |
|------|---------|------|---------|---------|------|
| Ингэ | 226.9   | 1961 | Эм хонь | 7786.1  | 1990 |
| Гүү  | 737.0   | 1996 | Эм ямаа | 3876.6  | 1996 |
| Үнээ | 1215.4  | 1996 |         |         |      |

**Төл бойжилт.** 1996 онд гарсан төлийн 92.6 хувь буюу 9047.5 мянган төл бойжуулав. Бойжсон төлийн тоо өмнөх оныхоос 35.1 мянгаар нэмэгджээ. Бойжуулсан нийт төлөөс 6.6 мянгыг каракуль арьсанд нядалжээ. ( Хавсралт хуудасны дугаар 17 )

Төл бойжилт ( мян.тол )

|                | Бүгд   | Ү Ү Н Э Э С |       |       |        |        | 1996-1995 зөрүү |
|----------------|--------|-------------|-------|-------|--------|--------|-----------------|
|                |        | ботго       | унага | тугал | хурга  | ишиг   |                 |
| Гарсан         | 9774.4 | 40.9        | 496.5 | 948.6 | 5206.0 | 3082.4 | 88.5            |
| Бойжсон        | 9047.5 | 37.0        | 467.2 | 918.1 | 4873.3 | 2751.9 | 35.1            |
| Хорогдсон      | 726.9  | 3.9         | 29.3  | 30.5  | 332.7  | 330.5  | 53.4            |
| Бойжилтын хувь | 92.6   | 90.6        | 94.1  | 96.8  | 93.6   | 89.3   | -0.4            |

Бойжуулсан төл ( мян.тол )

|       | 1991-1995 оны дундаж | 1991   | 1992   | 1993   | 1994   | 1995   | 1996   |
|-------|----------------------|--------|--------|--------|--------|--------|--------|
| Ботго | 42.3                 | 52.9   | 44.7   | 35.6   | 36.7   | 40.5   | 37.0   |
| Унага | 357.4                | 343.8  | 314.9  | 289.8  | 387.6  | 451.2  | 467.2  |
| Тугал | 778.1                | 762.5  | 725.2  | 669.3  | 812.9  | 920.4  | 918.1  |
| Хурга | 5431.3               | 6468.8 | 5726.8 | 4906.6 | 5085.2 | 4969.2 | 4873.3 |
| Ишиг  | 2141.5               | 1983.7 | 1924.7 | 1860.5 | 2307.6 | 2631.1 | 2751.9 |
| Бүгд  | 8750.6               | 9611.7 | 8736.3 | 7761.8 | 8630.0 | 9012.4 | 9047.5 |

1996 онд хамгийн олон ишиг, унага бойжуулан авав.

1961 оноос хойших хугацаанд хамгийн олон төл бойжуулсан жил

|       | мян.төл | Он   |       | мян.төл | Он   |
|-------|---------|------|-------|---------|------|
| Бүгд  | 9673.3  | 1989 | Тугал | 920.4   | 1995 |
| Ботго | 74.4    | 1975 | Хурга | 6569.6  | 1989 |
| Унага | 467.2   | 1996 | Ишиг  | 2751.9  | 1996 |

1996 онд 100 эхээс бойжуулсан төлийг ноднингийнхтой жишиж үзвэл хурга 3-аар их, ботго, унага тус бүр 3-аар, тугал 1-ээр бага байна.

100 эхээс бойжуулсан төл

|       | 1991-1995 оны<br>дундаж | 1991 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 |
|-------|-------------------------|------|------|------|------|------|------|
| Ботго | 36                      | 38   | 35   | 32   | 37   | 40   | 37   |
| Унага | 61                      | 61   | 55   | 51   | 67   | 69   | 66   |
| Тугал | 72                      | 68   | 68   | 65   | 78   | 79   | 78   |
| Хурга | 77                      | 83   | 77   | 69   | 79   | 79   | 82   |
| Ишиг  | 78                      | 82   | 78   | 70   | 80   | 80   | 76   |
| Бүгд  | 76                      | 80   | 75   | 68   | 78   | 78   | 78   |

100 хээлтэгчээс Архангай, Баян-Өлгий, Булган, Завхан аймаг 86-90 төл бойжуулсан байхад Дархан-Уул, Орхон, Баянхонгор аймаг, Улаанбаатар хот 63-66 төл бойжуулжээ. ( Хавсралтын хуудасны дугаар 18 )

Хувийн малын 100 эхээс бойжуулсан төл аж ахуйн бусад хэвшлийнхээс 18-аар, үүний дотор ботго 22, унага 28, тугал 31, ишиг 12-оор илүү байна.

Хувийн аж ахуйн 100 эхээс бойжуулсан төл.

|       | 1991-1995 оны<br>дундаж | 1991 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 |
|-------|-------------------------|------|------|------|------|------|------|
| Ботго | 45                      | 51   | 49   | 42   | 39   | 42   | 37   |
| Унага | 69                      | 76   | 68   | 60   | 70   | 71   | 67   |
| Тугал | 82                      | 85   | 86   | 78   | 82   | 81   | 80   |
| Хурга | 88                      | 96   | 93   | 86   | 82   | 82   | 85   |
| Ишиг  | 84                      | 87   | 88   | 82   | 82   | 82   | 77   |
| Бүгд  | 85                      | 90   | 89   | 82   | 81   | 81   | 80   |

**Том малын зүй бус хорогдол.** 1996 оны эхний малын 2.1 хувь буюу 586.8 мянган том мал зүй бусаар хорогдсон нь урьд оныхоос 87.1 мянга, 1991-1995 оны дунджаас 386.2 мянгаар багассан байна.

Том малын зүй бус хорогдол

|       | 1991-<br>1995<br>оны<br>дундаж | 1991  | 1992  | 1993   | 1994  | 1995  | 1996  |
|-------|--------------------------------|-------|-------|--------|-------|-------|-------|
| Тэмээ | 16.6                           | 20.8  | 21.4  | 23.8   | 9.5   | 7.5   | 8.4   |
| Адуу  | 76.7                           | 72.7  | 80.6  | 140.4  | 41.6  | 48.1  | 53.2  |
| Үхэр  | 132.9                          | 104.6 | 118.1 | 278.9  | 78.3  | 84.6  | 79.8  |
| Хонь  | 579.1                          | 624.1 | 516.6 | 927.9  | 423.8 | 403.2 | 288.7 |
| Ямаа  | 167.7                          | 156.0 | 134.3 | 281.1  | 136.8 | 130.5 | 156.7 |
| Бүгд  | 973.0                          | 978.2 | 871.0 | 1652.1 | 690.0 | 673.9 | 586.8 |

Оны эхний малд зүй бус хорогдолын эзлэх хувь

|       | 1991-1995 оны дундаж | 1991 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 |
|-------|----------------------|------|------|------|------|------|------|
| Тэмээ | 3.7                  | 3.9  | 4.5  | 5.7  | 2.6  | 2.0  | 2.3  |
| Адуу  | 3.4                  | 3.2  | 3.6  | 6.4  | 1.9  | 2.0  | 2.0  |
| Үхэр  | 4.7                  | 3.7  | 4.2  | 9.9  | 2.9  | 2.8  | 2.4  |
| Хонь  | 4.0                  | 4.1  | 3.5  | 6.3  | 3.1  | 2.9  | 2.1  |
| Ямаа  | 2.9                  | 3.0  | 2.6  | 5.0  | 2.2  | 1.8  | 1.8  |
| Бүгд  | 3.8                  | 3.8  | 3.4  | 6.4  | 2.7  | 2.5  | 2.1  |

Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Дорнод аймаг, Улаанбаатар хотын оны эхний малын 3.4-5.7 хувь, Баянхонгор, Хэнтий, Сүхбаатар, Өвөрхангай, Ховд аймагт 2.7-2.9 хувь буюу нийтдээ 318.2 мянган том мал зүй бусаар хорогдсон нь улсын хэмжээний нийт хорогдолын 54.2 хувийг эзлэж байна. ( Хавсралт хуудасны дугаар 19 )

Том малын зүй бус хорогдолын 36.0 хувь буюу 211.4 мянга нь өвчнөөр, 14.9 хувь буюу 87.7 мянга нь гэнэтийн аюулаар хорогдов. Хорогдсон нийт малын 82.5 хувь нь хувийн мал байна.

Хувийн малын 1.8 хувь, аж ахуйн бусад хэвшлийн малын 4.8 хувь хорогджээ.

1961 оноос хойш малын зүй бус хорогдол хамгийн бага болон их гарсан жил

|       | Хамгийн бага хорогдол гарсан |      | Хамгийн их хорогдол гарсан |      |
|-------|------------------------------|------|----------------------------|------|
|       | мян.тол                      | он   | мян.тол                    | он   |
| Бүгд  | 510.3                        | 1989 | 2663.8                     | 1968 |
| Тэмээ | 7.5                          | 1996 | 66.3                       | 1966 |
| Адуу  | 41.6                         | 1994 | 235.3                      | 1968 |
| Үхэр  | 52.3                         | 1974 | 278.9                      | 1993 |
| Хонь  | 288.7                        | 1996 | 1606.3                     | 1968 |
| Ямаа  | 89.3                         | 1989 | 574.8                      | 1968 |

**Малын хээл хаялт, сувайралт.** 1996 оны эхний хээлтэгч малын 11.5 хувь буюу 1324.3 мянга нь хээл хаяж, сувайрсан нь 1991-1995 оны дунджаас 14.2 хувь буюу 219.1 мянгаар буурсан хэдий ч үнээ, гүү, эм ямааны хээл хаялт, сувайралт 1995 оныхоос 6.4-31.3 хувь буюу 11.6-104.3 мянгаар нэмэгдсэн байна.

Сэлэнгэ, Дархан-Уул аймаг оны эхний хээлтэгч малынхаа 20.2-21.1, Орхон, Баянхонгор, Дорнод аймаг 17.1-19.9 хувиас дээрхи шалтгаанаар төл авч чадсангүй. ( Хавсралтын хуудасны дугаар 20-22 )

Дархан-Уул, Орхон, Баянхонгор аймаг, Улаанбаатар хот 1996 онд 100 эхээс улсын дунджаас 13-15 толгойгоор бага төл бойжуулсан нь хээл хаялт, сувайралт их гарснаас голлон шалтгаалсан байна.

Хээл хаяж, сувайрсан эх малын тоо ( мян.тол )

|         | Төл өгөөгүй хээлтэгч мал бүгд |        |        |                | үүнээс: сувайрсан |       |       |
|---------|-------------------------------|--------|--------|----------------|-------------------|-------|-------|
|         | 1991-1995 дундаж              | 1995   | 1996   | 1996\1995 хувь | 1990-1995 дундаж  | 1995  | 1996  |
| Ингэ    | 14.1                          | 9.7    | 9.4    | 96.9           | 11.3              | 7.9   | 7.4   |
| Гүү     | 182.1                         | 152.3  | 173.0  | 113.6          | 138.7             | 117.4 | 131.5 |
| Үнээ    | 236.3                         | 181.1  | 192.7  | 106.4          | 189.0             | 143.7 | 153.5 |
| Эм хонь | 767.0                         | 600.3  | 512.0  | 85.3           | 538.6             | 418.5 | 351.9 |
| Эм ямаа | 343.9                         | 332.9  | 437.2  | 131.3          | 205.8             | 202.2 | 229.2 |
| ДҮН     | 1543.4                        | 1276.3 | 1324.3 | 103.8          | 1083.4            | 889.7 | 873.5 |

Нийт хээлтэгчид хээл хаяж, сувайрсан эх малын эзлэх хувь

|         | Бүгд      |      |      | үүнээс: сувайрсан |      |      |
|---------|-----------|------|------|-------------------|------|------|
|         | 1990-1995 | 1995 | 1996 | 1990-1995         | 1995 | 1996 |
| Ингэ    | 12.1      | 9.7  | 9.2  | 9.7               | 7.9  | 7.3  |
| Гүү     | 31.3      | 23.4 | 24.5 | 23.8              | 18.1 | 18.6 |
| Үнээ    | 21.8      | 15.5 | 16.4 | 17.4              | 12.3 | 13.0 |
| Эм хонь | 10.9      | 9.5  | 8.6  | 7.7               | 6.6  | 5.9  |
| Эм ямаа | 12.7      | 10.2 | 12.1 | 7.6               | 6.2  | 6.4  |
| ДҮН     | 13.4      | 11.1 | 11.5 | 9.3               | 7.7  | 7.6  |

1961 оноос хойш эх малын хээл хаялт, сувайралт хамгийн бага болон их гарсан жил

|         | Хамгийн бага |      | Хамгийн их |      |
|---------|--------------|------|------------|------|
|         | мян.тол      | он   | мян.тол    | Он   |
| Бүгд    | 645.8        | 1963 | 1907.9     | 1977 |
| Ингэ    | 9.4          | 1996 | 26.4       | 1973 |
| Гүү     | 152.3        | 1995 | 333.6      | 1973 |
| Үнээ    | 106.1        | 1962 | 326.0      | 1981 |
| Эм хонь | 190.6        | 1962 | 913.0      | 1993 |
| Эм ямаа | 124.7        | 1963 | 558.1      | 1968 |

**Хээлтээгч, хээлтүүлэгчийн тохироо.** Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой байхад одоо улсын дунджаар 57 эм хонь, 54 эм ямаа ногдож, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо алдагдсан хэвээр байна.

Хээлтүүлэгч малын тоо ( мян.тол )

|        | Бүгд  |       |       |           | үүнээс: шинээр тавьсан |      |      |
|--------|-------|-------|-------|-----------|------------------------|------|------|
|        | 1994  | 1995  | 1996  | 1996\1995 | 1994                   | 1995 | 1996 |
| Буур   | 4.7   | 4.8   | 4.7   | 97.9      | 62                     | 95   | 64   |
| Азрага | 92.9  | 101.0 | 104.8 | 103.8     | 0.7                    | 1.5  | 1.0  |
| Бух    | 57.0  | 58.4  | 58.3  | 99.8      | 1.0                    | 1.7  | 1.1  |
| Хуц    | 100.4 | 104.0 | 102.0 | 98.1      | 2.5                    | 3.7  | 3.1  |
| Ухна   | 55.9  | 68.6  | 72.2  | 105.2     | 1.1                    | 2.1  | 2.5  |
| ДҮН    | 310.9 | 336.8 | 342.0 | 101.5     | 5.4                    | 9.1  | 7.7  |

Нэг хээлтүүлэгчид ногдох хээлтэгч малын тоо

|         | Үржлийн норм | 1995 | 1996 | Хувийн |      | Бусад хэвшлийн |      |
|---------|--------------|------|------|--------|------|----------------|------|
|         |              |      |      | 1995   | 1996 | 1995           | 1996 |
| Ингэ    | 20-25        | 21   | 21   | 21     | 21   | 26             | 26   |
| Гүү     | 12-15        | 7    | 7    | 7      | 7    | 11             | 10   |
| Үнээ    | 35-45        | 20   | 21   | 20     | 21   | 17             | 16   |
| Эм хонь | 25-30        | 57   | 57   | 58     | 58   | 52             | 55   |
| Эм ямаа | 25-30        | 53   | 54   | 53     | 54   | 46             | 56   |

Говь-Алтай, Завхан, Төв, Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул, Булган, Дорноговь, Өвөрхангай аймагт хуц, Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай, Өвөрхангай аймагт ухна бусдаас илүү дутагдалтай байна. ( Хавсралтын хуудасны дугаар 23 )

**Малын хэрэглээний зарлага.** Оны эхний нийт малын 27.0 хувьтай тэнцэх 7726.3 мянган малыг хүнсний хэрэгцээнд зарцуулсан нь 1995 оныхоос 1.1 сая толгойгоор нэмэгдсэн байна. Олон жилийн дунджаар ямааны 31-33 хувийг хүнсэнд хэрэглэдэг байсан бол 1994 онд 17 хувь, 1995 онд 16.9 хувь болж буурснаа 1996 онд 23.3 хувь болж нэмэгдлээ. ( Хавсралтын хуудасны дугаар 24 )

Малын нийт хэрэглээний зарлага. ( мян.тол )

|       | 1991-1995 оны дундаж | 1991   | 1992   | 1993   | 1994   | 1995   | 1996   |
|-------|----------------------|--------|--------|--------|--------|--------|--------|
| Бүгд  | 7219.3               | 8930.5 | 7683.5 | 6617.8 | 6297.6 | 6567.3 | 7726.3 |
| Тэмээ | 59.4                 | 93.6   | 84.1   | 59.3   | 28.6   | 31.6   | 38.3   |
| Адуу  | 203.5                | 273.8  | 293.4  | 159.4  | 127.5  | 163.5  | 291.9  |
| Үхэр  | 551.5                | 684.6  | 609.9  | 479.1  | 459.9  | 523.9  | 679.0  |
| Хонь  | 5110.1               | 6174.6 | 5258.6 | 4845.2 | 4645.0 | 4627.1 | 4736.0 |
| Ямаа  | 1294.8               | 1703.9 | 1437.5 | 1074.8 | 1036.6 | 1221.2 | 1981.1 |



1996 оны эцэст 7030.1 мянган нас гүйцсэн эр мал тоологдсон нь өмнөх оныхоос 387.3 мянгаар нэмэгдсэний дотор эр ямаа 281.1 мянга, эр хонь 77.7 мянга, адуу 21.5 мянга, үхэр 11.5 мянгаар өсч, тэмээ 4.5 мянгаар буурлаа.

**Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн мал.** 1996 оны эцэст цэвэр үүлдрийн 737.0 мянга, эрлийз 960.7 мянга, нутгийн шилдэг омгийн 695.0 мянган мал тоологдов. Цэвэр үүлдрийн мал 1995 оныхоос 2.5 хувь буюу 19.1 мянгаар буурч, эрлийз 6.8 хувь буюу 60.3 мянга, нутгын шилдэг омгын мал 13.2 хувь буюу 81.0 мянгаар нэмэгдэв. (Хавсралт хуудасны дугаар 25,26 )

1996 онд тоологдсон нийт үхрийн 4.9 хувь, хонины 9.3 хувь, ямааны 2.9 хувийг цэвэр, эрлийз мал эзлэж байна. Нийт цэвэр, эрлийз малын 82.4 хувь нь хувийн аж ахуйд, 14.9 хувь нь хөдөө аж ахуйн компани, хоршоо, улсын үйлдвэрийн газар, бусад байгууллагад байна.

1996 оны эцэст цэвэр үүлдрийн болон эрлийз 808.2 мянган хээлтэгч мал тоологдов. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын сүрэгт үнээ 40.3 хувь, эм хонь 48.5 хувь, эм ямаа 48.0 хувийг эзлэж байна.

Нутгийн шилдэг омгийн 4.3 мянган тэмээ, 7.5 мянган адуу, 3.3 мянган үхэр, 555.0 мянган хонь, 124.9 мянган ямаа тоологдлоо.

Цэвэр үүлдрийн болон эрлийз, нутгийн шилдэг омгийн  
малын тоо, төрлөөр ( мян.тол )

|                                 | 1993  | 1994  | 1995  | 1996  | 1996\1995 |       |
|---------------------------------|-------|-------|-------|-------|-----------|-------|
|                                 |       |       |       |       | хувь      | зөрүү |
| <b>1.Цэвэр үүлдрийн бүх мал</b> | 334.8 | 338.6 | 756.1 | 737.0 | 97.5      | -19.1 |
| үхэр                            | 46.2  | 39.3  | 51.4  | 53.5  | 104.1     | 2.1   |
| хонь                            | 221.8 | 226.6 | 626.8 | 608.1 | 97.0      | -18.7 |
| ямаа                            | 66.8  | 72.7  | 77.9  | 75.4  | 96.8      | -2.5  |
| <b>2. Эрлийз</b>                | 666.6 | 583.0 | 900.4 | 960.7 | 106.7     | 60.3  |
| үхэр                            | 100.3 | 94.4  | 112.8 | 115.9 | 102.7     | 3.1   |
| хонь                            | 424.9 | 348.9 | 600.5 | 654.7 | 109.0     | 54.2  |
| ямаа                            | 141.4 | 139.7 | 187.1 | 190.1 | 101.6     | 3.0   |
| <b>3.Нутгийн шилдэг омгийн</b>  | 824.7 | 846.1 | 614.0 | 695.0 | 113.2     | 81.0  |
| үхэр                            | 17.5  | 25.5  | 3.1   | 3.3   | 106.5     | 0.2   |
| хонь                            | 768.0 | 770.0 | 536.7 | 555.0 | 103.4     | 18.3  |
| ямаа                            | 39.2  | 50.6  | 65.2  | 124.9 | 191.6     | 59.7  |
| тэмээ                           |       |       | 2.0   | 4.3   | 215.0     | 2.3   |
| адуу                            |       |       | 7.0   | 7.5   | 107.1     | 0.5   |

Цэвэр үүлдэр, эрлийз малын тоо, аж ахуйн салбараар. ( мян.тол )

|                              | Нийт цэвэр, эрлийз мал |        | Үхэр  |       | Хонь   |        | Ямаа  |       |
|------------------------------|------------------------|--------|-------|-------|--------|--------|-------|-------|
|                              | 1995                   | 1996   | 1995  | 1996  | 1995   | 1996   | 1995  | 1996  |
| ХАА-н компани, хоршоо, УУГ   | 312.8                  | 252.5  | 64.5  | 47.3  | 241.8  | 196.2  | 6.5   | 9.0   |
| Хувийн аж ахуй               | 1298.3                 | 1399.4 | 95.8  | 118.7 | 948.6  | 1026.5 | 253.9 | 254.2 |
| Бусад                        | 45.4                   | 45.8   | 3.9   | 3.4   | 36.9   | 40.1   | 4.6   | 2.3   |
| ДҮН                          | 1656.5                 | 1697.7 | 164.2 | 169.4 | 1227.3 | 1262.8 | 265.0 | 265.5 |
| Салбаруудын эзлэх хувийн жин |                        |        |       |       |        |        |       |       |
| ХАА-н компани, хоршоо, УУГ   | 18.9                   | 14.9   | 39.3  | 27.9  | 19.7   | 15.5   | 2.5   | 3.4   |
| Хувийн аж ахуй               | 78.4                   | 82.4   | 58.3  | 70.1  | 77.3   | 81.3   | 95.8  | 95.7  |
| Бусад                        | 2.7                    | 2.7    | 2.4   | 2.0   | 3.0    | 3.2    | 1.7   | 0.9   |
| Дүн                          | 100                    | 100    | 100   | 100   | 100    | 100    | 100   | 100   |

Нийт малд цэвэр үүлдрийн болон эрлийз малын эзлэх хувь

|                | Үхэр |      | Хонь |      | Ямаа |      |
|----------------|------|------|------|------|------|------|
|                | 1995 | 1996 | 1995 | 1996 | 1995 | 1996 |
| Бүгд           | 4.9  | 4.9  | 8.9  | 9.3  | 3.1  | 2.9  |
| цэвэр          | 1.5  | 1.6  | 4.5  | 4.5  | 0.9  | 0.8  |
| эрлийз         | 3.4  | 3.3  | 4.4  | 4.8  | 2.2  | 2.1  |
| Хувийн аж ахуй | 3.1  | 3.5  | 7.8  | 8.4  | 3.1  | 2.9  |
| цэвэр          | 0.6  | 0.6  | 3.8  | 3.9  | 0.9  | 0.8  |
| эрлийз         | 2.5  | 2.9  | 4.0  | 4.5  | 2.2  | 2.1  |
| ХАА-н газрууд  | 65.5 | 60.5 | 34.2 | 33.1 | 6.6  | 9.4  |
| цэвэр          | 32.0 | 39.8 | 23.0 | 20.6 |      | 3.2  |
| эрлийз         | 33.5 | 20.7 | 11.2 | 12.5 | 6.6  | 6.2  |

Цэвэр үүлдрийн болон эрлийз хээлтэгч малын тоо ( мян.тол )

|                          | 1993  | 1994  | 1995  | 1996  | 1996\1995 |       |
|--------------------------|-------|-------|-------|-------|-----------|-------|
|                          |       |       |       |       | Хувь      | Зөрүү |
| 1.Цэвэр үүлдрийн бүх мал | 180.9 | 178.4 | 375.4 | 358.6 | 95.5      | -16.8 |
| Үнээ                     | 22.1  | 20.7  | 22.3  | 22.8  | 102.2     | 0.5   |
| Эм хонь                  | 122.4 | 118.8 | 312.9 | 297.5 | 95.1      | -15.4 |
| Эм ямаа                  | 36.4  | 38.9  | 40.2  | 38.3  | 95.3      | -1.9  |
| 2.Эрлийз үүлдрийн        | 333.8 | 297.6 | 425.9 | 449.6 | 105.6     | 23.7  |



|         |       |       |       |       |       |      |
|---------|-------|-------|-------|-------|-------|------|
| Үнээ    | 39.6  | 45.1  | 47.7  | 45.5  | 95.4  | -2.2 |
| Эм хонь | 225.1 | 179.8 | 288.2 | 314.9 | 109.3 | 26.7 |
| Эм ямаа | 69.1  | 72.7  | 90.0  | 89.2  | 99.1  | -0.8 |

Цэвэр үүлдрийн болон эрлийз малын хээлтэгчийн эзлэх хувь

|                | Үнээ |      | Эм хонь |      | Эм ямаа |      |
|----------------|------|------|---------|------|---------|------|
|                | 1995 | 1996 | 1995    | 1996 | 1995    | 1996 |
| Бүгд           | 42.6 | 40.3 | 49.0    | 48.5 | 49.1    | 48.0 |
| цэвэр          | 43.4 | 42.6 | 49.9    | 48.9 | 51.7    | 50.8 |
| эрлийз         | 42.3 | 39.3 | 48.0    | 48.1 | 48.1    | 46.9 |
| Хувийн аж ахуй | 41.1 | 38.9 | 47.4    | 46.9 | 48.1    | 47.7 |
| цэвэр          | 37.9 | 40.6 | 47.3    | 46.5 | 48.8    | 49.8 |
| эрлийз         | 41.9 | 38.6 | 47.4    | 47.2 | 47.8    | 46.9 |
| ХАА-н газрууд  | 44.7 | 43.7 | 55.0    | 56.2 | 56.7    | 45.8 |
| цэвэр          | 46.4 | 43.8 | 57.4    | 57.4 |         | 45.0 |
| эрлийз         | 43.0 | 43.5 | 50.3    | 54.2 | 56.7    | 46.2 |

**Мал аж ахуйн мэргэжилтний хүрэлцээ, хангамж.** 1996 онд мал аж ахуйн үйлдвэрлэлд 421 мал зүйч, 1539 малын эмч ажиллаж байгаа нь 1995 оныхоос мал зүйчийн тоо 36.7 хувиар нэмэгдэж, малын эмчийн тоо 5.8 хувиар буурсан байна. 1996 онд улсын дунджаар нэг мал зүйчид 69.6 мянга, малын нэг эмчид 19.0 мянган мал ногдож байна.

Сэлэнгэ аймагт нэг мал зүйчид 10.1 мянган мал ногдож байхад Архангай, Хөвсгөл, Говь-Алтай, Баян-Өлгий, Өвөрхангай аймагт 102.0-123.2 мянган толгой мал ногдож байна. ( Хавсралт хуудасны дугаар 27 )

Мал аж ахуйн мэргэжилтний тоо, хангамж.

|  | 1989 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 | 1996\1995 хувь |
|--|------|------|------|------|------|------|----------------|
| Мал зүйч                                     | 787  | 501  | 485  | 379  | 308  | 421  | 136.7          |
| Малын эмч                                    | 1599 | 1661 | 1668 | 1715 | 1634 | 1539 | 94.2           |
| Нэг мал зүйчид ногдох малын тоо ( мян.тол )  | 32.4 | 51.3 | 51.9 | 70.7 | 92.8 | 69.6 | 75.0           |
| Нэг малын эмчид ногдох малын тоо ( мян.тол ) | 16.0 | 15.5 | 15.1 | 15.6 | 17.5 | 19.0 | 108.6          |

**III.2. Малын хашаа, уст цэг, малын тэжээлийн хангамж**

**III. Малын хашаа, худаг.** 1996 оны эцэст улсын хэмжээгээр 27.6 сая малын багтаамжтай 104.4 мянган хашаа тоологдсон нь ноднин жилийнхээс хашааны тоо 8.2 мянгаар, багтаамж нь 0.6 сая толгойгоор тус тус нэмэгдсэн байна.

Нийт хашааны 10.7 хувь нь дулаан байр, дулаалгатай хашаа, 68.2 хувь нь саравчтай хашаа, 21.1 хувь нь саравчгүй хашаа байна. Эдгээр хашааны 93.2 хувь

нь хувийн аж ахуйд байна. Богийн 25.4 сая толгой малын багтаамжтай 79.4 мянган хашаа тоологдов.

1996 онд 1596.8 мянган толгой малын багтаамжтай 6525 хашаа шинээр ашиглалтанд оруулсан нь ноднин жилийнхээс 3193-аар бага байна.

Дорноговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Орхон, Дархан-Уул аймгийн малын хашааны багтаамж ноднин жилийнхээс 10.9-418.4 мянган толгойгоор буурсан байна.

Малын хашааны тоо, багтаамж, хувиар

|                            | 1986-1990<br>оны<br>дундаж | 1991-1995<br>оны<br>дундаж | 1994  | 1995  | 1996  | 1996\1995<br>хувь |
|----------------------------|----------------------------|----------------------------|-------|-------|-------|-------------------|
| Хашаа бүгд (мян)           | 67.8                       | 79.2                       | 84.1  | 93.2  | 101.4 | 108.7             |
| Багтаамж (сая.тол)         | 31.4                       | 27.2                       | 27.1  | 27.0  | 27.6  | 102.3             |
| Шинээр барьсан хашааны тоо | 201.5                      | 6043                       | 7848  | 9718  | 6525  | 67.1              |
| Багтаамж (сая.тол)         | 0.9                        | 1.4                        | 1.2   | 2.4   | 1.6   | 67.2              |
| Хашаажилтын хувь           |                            |                            |       |       |       |                   |
| Бод                        | 105.6                      | 66.8                       | 61.8  | 60.2  | 57.5  | 95.5              |
| Бог                        | 154.7                      | 121.7                      | 118.8 | 111.2 | 111.8 | 100.5             |

1996 оны байдлаар бог мал 1.1 ээлжийн хашаагаар, үхрийн 57.5 хувь нь нэг ээлжийн хашаагаар хангагдсан байна.

Дорноговь, Увс, Дорнод, Сүхбаатар, Төв, Орхон, Хэнтий аймагт бог малын хашааны хангамж бусад аймгаас харьцангуй доогуур байна. ( Хавсралт хуудасны дугаар 28 – 30 )

**Уст цэг.** Улсын хэмжээгээр 1986-1990 онд дунджаар 41.9 мянган худагтай байсан бол 1996 оны эцэст 34.4 мянган худаг тоологджээ. 1996 онд шинээр 772 худаг ашиглалтанд оруулсны 752 нь энгийн уурхайн худаг байна.

1995 оныхоос энгийн уурхайн худаг 1401 –ээр нэмэгдэж, инженерийн байгууламжтай худаг 1615-аар буурчээ. Нийт худгийн тоо 1995 оныхоос Говь-Алтай, Ховд, Увс, Өвөрхангай, Архангай, Баянхонгор зэрэг 11 аймагт 576-аар өсч, бусад 9 аймаг, Улаанбаатар хотод 790-ээр буурсны дотор Өмнөговь, Дундговь, Дархан-Уул, Булган, Сүхбаатар аймаг, Улаанбаатар хотод 58-206 худгаар багасчээ. ( Хавсралт хуудасны дугаар 31 )

Уст цэгийн тоо ( мян.ш )

|                          | 1986-1990<br>оны<br>дундаж | 1991-1995<br>оны<br>дундаж | 1994 | 1995 | 1996 | 1996\1995<br>хувь |
|--------------------------|----------------------------|----------------------------|------|------|------|-------------------|
| Худаг бүгд               | 41.9                       | 36.1                       | 35.6 | 34.6 | 34.4 | 99.4              |
| Үүнээс :                 |                            |                            |      |      |      |                   |
| Инженерийн байгууламжтай | 25.0                       | 18.9                       | 17.5 | 14.6 | 13.0 | 88.9              |
| Энгийн уурхайн           | 16.9                       | 17.2                       | 18.1 | 20.0 | 21.4 | 107.0             |
| Мал услах сан            | 4.2                        | 2.6                        | 2.2  | 1.9  | 1.7  | 89.6              |

Улсын хэмжээгээр 1996 онд 20.1 мянган м.куб багтаамжтай мал услах 1733 сан тоологдсон нь нодин жилийнхээс 201-ээр буурсан байна. 27.3 мянган га талбай услах хүчин чадалтай 94 услалтын систем тоологдож, 1995 оныхоос услалтын систем 6-аар , хүчин чадал нь 919.9 га-аар өсчээ. ( Хавсралт хуудасны дугаар 32 )

1996 онд эвдрэлтэй, ашиглагдаггүй худаг 6267 байгаа нь ноднин жилийнхээс 1.1 хувиар нэмэгджээ.

Ашиглалтгүй худгийг аймгаар үзүүлбэл :

| Ашиглалтгүй байгаа худгийн тоо | Аймаг   |
|--------------------------------|---|
| 48 – 184                       | Завхан, Сэлэнгэ, Булган, Баян-Өлгий, Дархан-Уул                                     |
| 201 - 298                      | Архангай, Ховд, Өвөрхангай, Сүхбаатар, Увс  |
| 326 - 804                      | Дорноговь, Хэнтий, Өмнөговь, Төв, Дундговь, Хөвсгөл, Говь-Алтай, Дорнод, Баянхонгор |

**Малын тэжээл үйлдвэрлэлт.** 1996 онд улсын хэмжээгээр 349.2 мян.тонн тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний тэжээл үйлдвэрлэсэн нь 1995 оныхоос 88.1 мян.тонноор буюу 20.2 хувиар буурчээ.

Үйлдвэрлэсэн тэжээлийг нэр төрлөөр нь авч үзвэл олон наст өвсний хэмжээ өмнөх оныхоос нэмэгдэж, харин бэлтгэсэн өвс, сүрэл, нэг наст өвс, гар ба эрдэс тэжээл, багсармал тэжээл, бэлтгэсэн даршны хэмжээ 10.3-78.2 хувиар багассан байна.

Тэжээл үйлдвэрлэлийн хэмжээ ( тэжээлийн хэгжид шилжүүлснээр ) 16 аймаг, Улаанбаатар хотод буурсны дотор Сүхбаатар, Өвөрхангай, Архангай, Увс, Говьсүмбэр аймагт 31.3-64.0 хувиар багасчээ.

1996 онд улсын хэмжээгээр 701.3 мян.тонн байгалийн хадлан бэлтгэсэн нь өнгөрсөн оныхоос 80.2 мянган тонноор буюу 10.3 хувь буурчээ. Ховд, Баян-Өлгий, Дорнод, Дархан-Уул, Орхон, Сүхбаатар зэрэг 17 аймагт бэлтгэсэн өвсний хэмжээ 1995 оныхоос 1.0-49.9 хувиар буурсан байна. ( Хавсралт хуудасны дугаар 33-36 )

Тэжээлийн хэмжээг зарим нэр төрлөөр үзүүлбэл : ( мян.тонн )

|                                | 1986-1990 оны дундаж | 1991-1995 оны дундаж | 1994  | 1995  | 1996  | 1996\1995 хувь |
|--------------------------------|----------------------|----------------------|-------|-------|-------|----------------|
| Байгалийн хадлан               | 1154.2               | 733.7                | 691.8 | 781.5 | 701.3 | 89.7           |
| Сүрэл                          | 114.1                | 47.2                 | 22.3  | 100.6 | 21.9  | 21.8           |
| Нэг наст өвс                   | 255.6                | 23.9                 | 4.0   | 6.3   | 1.6   | 25.2           |
| Олон наст өвс                  | 21.8                 | 4.7                  | 1.4   | 0.7   | 0.8   | 113.0          |
| Гар тэжээл(тэ.нэгж)            | 21.7                 | 9.6                  | 11.6  | 15.0  | 9.8   | 64.9           |
| Багсармал тэжээл               | 139.8                | 17.5                 | 13.8  | 13.8  | 4.8   | 34.5           |
| Бэлтгэсэн дарш                 | 277.7                | 66.2                 | 30.5  | 19.2  | 10.4  | 54.2           |
| Эрдэс тэжээл                   | 61.9                 | 18.1                 | 18.9  | 26.3  | 18.3  | 69.4           |
| Үйлдвэрлэсэн тэжээл (тэж.нэгж) | 999.4                | 437.9                | 373.3 | 437.3 | 349.2 | 79.8           |

Сүүлийн жилүүдэд нийт тэжээлд хүчит болон шүүст тэжээлийн эзлэх хувийн жин буурч байна.

### Үйлдвэрлэсэн тэжээлийн бүтэц, хувиар

|      | 1986-1990<br>оны дундаж | Ү ү н э э с |       |        |       |
|------|-------------------------|-------------|-------|--------|-------|
|      |                         | Хүчит       | Шүүст | Бүдүүн | Бусад |
| 1991 | 100.0                   | 15.2        | 5.3   | 77.6   | 1.9   |
| 1992 | 100.0                   | 11.5        | 7.1   | 81.4   | -     |
| 1993 | 100.0                   | 15.3        | 3.9   | 80.8   | -     |
| 1994 | 100.0                   | 9.5         | 2.2   | 88.3   | -     |
| 1995 | 100.0                   | 7.4         | 1.8   | 87.4   | 3.4   |
| 1996 | 100.0                   | 3.3         | 1.4   | 92.5   | 2.8   |

1996 оны байдлаар хонин толгойд шилжүүлсэн нэг малд ногдох тэжээл 1995 оныхоос 1.6 кг-аар багасч, тэжээлийн нэгжээр 5.5 кг тэжээл ногдож байгаа нь нийт малыг 2.8 хоног тэжээх нөөцтэй гэсэн үг юм.

### II.2. Тэжээвэр амьтад.

1996 оны эцэст 19.1 мянган гахай, 58.0 мянган шувуу, туулай 122, үнэг 180 тоологдов. 1995 оныхоос гахайн тоо 4.4 мянга, шувууны тоо 41.3 мянгаар буурч, 1991 оныхоос гахайн тоо 4.4 дахин, шувууны тоо 3.9 дахин цөөрлөө.

Тэжээвэр амьтад, тэдгээрийг өсгөж, үржүүлдэг өрх,  
аж ахуйн тоо

|  | 1991  | 1992  | 1993  | 1994 | 1995 | 1996 | 1996\1995 |
|--|-------|-------|-------|------|------|------|-----------|
| Гахай<br>(мян.тол)   | 83.3  | 48.6  | 28.6  | 23.4 | 23.5 | 19.1 | 81.2      |
| Шувуу<br>(мян.тол)   | 223.3 | 184.0 | 131.6 | 74.1 | 99.3 | 58.0 | 58.4      |
| Цаа буга   | 1336  | 1427  | 141.5 | 1170 | 900  | 668  | 74.2      |
| Илжиг, луус  | 791   | 935   | 874   | 993  | 913  | 1064 | 116.5     |
| Зөгий бүл  | 4567  | 1473  | 1237  | 1386 | 1165 | 1075 | 92.3      |
| Туулай   | 2047  | 164   | 142   | 129  | 118  | 122  | 103.4     |
| Үнэг   | 1209  | 1001  | 1060  | 215  | 568  | 180  | 31.7      |
| Булга  | 7513  | 6005  | 4571  | 2696 | 180  | -    | 0.0       |
| Гахайтай<br>өрхийн тоо<br>(мян)                            | 12.1  | 7.6   | 5.4   | 4.1  | 4.2  | 3.4  | 82.5      |
| Шувуутай<br>өрхийн тоо<br>(мян)                            | 1336  | 1569  | 1813  | 1792 | 2218 | 1643 | 74.1      |
| Гахай өсгөж<br>үржүүлдэг<br>аж ахуй, байгуу-<br>ллагын тоо | 482   | 225   | 148   | 97   | 111  | 90   | 81.1      |

|   |    |    |    |    |    |    |      |
|---|----|----|----|----|----|----|------|
| Шувуу өсгөж үржүүлдэг аж ахуй, байгууллагын тоо | 56 | 37 | 33 | 22 | 25 | 17 | 68.0 |
|---|----|----|----|----|----|----|------|

Нийт гахайн тоо 1995 оныхоос Өвөрхангай, Архангай, Дундговь зэрэг 5 аймаг, Улаанбаатар хотод нийтдээ 924 толгойгоор өсч, бусад 13 аймагт 5352 толгойгоор хорогдов. Шувууны тоо Булган, Баянхонгор, Хөвсгөл зэрэг 5 аймагт 621 толгойгоор өсч, бусад 14 аймаг, Улаанбаатар хотод 41.9 мянган толгойгоор буурсан байна. ( Хавсралт хуудасны дугаар 37 – 39 )

1996 онд аминдаа гахайтай өрх 3.4 мянга, шувуутай өрх 1.6 мянга болсон нь 1995 оныхоос гахайтай өрх 729-ээр, шувуутай өрх 575-аар буурсан байна. Гахайтай өрхийн тоо Өвөрхангай, Сүхбаатар, Хөвсгөл аймагт, шувуутай өрхийн тоо Сэлэнгэ, Өвөрхангай, Өмнөговь, Баянхонгор, Хөвсгөл, Дундговь, Ховд, Дорноговь, Сүхбаатар аймагт өссөн байна.

Одоо нийт гахайны 80.1 хувь, шувууны 26.7 хувь хувийн аж ахуйд байна.

Гахай, шувууны тоо, өмчийн төрлөөр ( мян.тол )

|                | Гахай |      |                |            | Үндсэн мэгж (толгой) |      |                | Хувийн жин |
|----------------|-------|------|----------------|------------|----------------------|------|----------------|------------|
|                | 1995  | 1996 | 1996\1995 хувь | Хувийн жин | 1995                 | 1996 | 1996\1995 хувь |            |
| Дүн            | 23.5  | 19.1 | 81.2           | 100.0      | 6376                 | 5624 | 88.2           | 100.0      |
| Үүнээс: хувийн | 18.9  | 15.3 | 80.8           | 80.1       | 5183                 | 4620 | 89.1           | 82.1       |

үргэлжлэл

|                | Шувуу |      |                |            | Өндөглөгч ( мян.тол ) |      |                | Хувийн жин |
|----------------|-------|------|----------------|------------|-----------------------|------|----------------|------------|
|                | 1995  | 1996 | 1996\1995 хувь | Хувийн жин | 1995                  | 1996 | 1996\1995 хувь |            |
| Дүн            | 99.3  | 58.0 | 58.4           | 100.0      | 33.7                  | 27.5 | 81.7           | 100.0      |
| Үүнээс: хувийн | 19.9  | 15.5 | 77.7           | 26.7       | 12.3                  | 9.7  | 78.4           | 35.1       |

### III. Малчдын тоо, тэдний соёл, ахуйн хангамж, орлого

**III.1. Малчдын тоо, насны бүлэг, нэг малчин өрхөд ногдох малын тоо.** 1996 оны жилийн эцсийн мал тооллогоор улсын хэмжээгээр аминдаа малтай 278.3 мянган өрх тоологдсоны 61.1 хувь буюу 170.1 мянга нь малчин өрх байв. Малчин өрхөд 395.4 мянган малчид ажиллаж байгаа нь нийт хүн амын 16.8 хувь болж байна. Малчдын тоо өмнөх оныхоос 1.3 хувь буюу 4.9 мянгаар нэмэгдэв.

Нийт малчдын 57.3 хувь нь 16-35 насны залуучууд, 27.6 хувь нь 36-аас тэтгэвэрт гарах хүртлэх насны хүмүүс байна.

Сүүлийн жилүүдэд малчдын дотор тэтгэвэрийн насныхны хүмүүсийн хувийн жин буурч, залуучуудын эзлэх хувь нэмэгдсээр иржээ. Малчдын тоо бага зэрэг нэмэгдсэн нь малчин өрхийн хүүхдүүдээс 16 нас хүрч малчдын эгнээг өргөжүүлж байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.

Өрх, малчдын тоо, бүрэлдэхүүн

|  | 1992  | 1993  | 1994  | 1995  | 1996  | 1996\1995<br>хувь |
|--|-------|-------|-------|-------|-------|-------------------|
| Малчин өрх<br>(мян)                                    | 143.4 | 153.6 | 167.3 | 169.3 | 170.1 | 100.5             |
| Малчдын<br>тоо (мян)                                   | 330.1 | 347.9 | 377.1 | 390.5 | 395.4 | 101.3             |
| Үүнээс:16-<br>34 насны                                 | 174.6 | 186.8 | 204.8 | 225.2 | 226.5 | 100.6             |
| 35-аас<br>тэтгэвэрт<br>гарах<br>хүртэл<br>насны        | 97.2  | 96.1  | 106.3 | 95.4  | 109.2 | 114.5             |
| Тэтгэврийн<br>насны                                    | 58.3  | 65.0  | 66.0  | 69.9  | 59.7  | 85.4              |
| Насны<br>бүрэлдэхүүн<br>( хувиар )                     | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 | 100.0 |                   |
| Үүнээс:16-<br>34 насны                                 | 52.9  | 53.7  | 54.3  | 57.7  | 57.3  |                   |
| 35-аас<br>тэтгэвэрт<br>гарах<br>хүртэл<br>насны        | 29.4  | 27.6  | 28.2  | 24.4  | 27.6  |                   |
| Тэтгэврийн<br>насны                                    | 17.7  | 18.7  | 17.5  | 17.9  | 15.1  |                   |
| Нэг малчин<br>өрхөд<br>ногдох<br>малын тоо*<br>( тол ) | 179   | 164   | 160   | 169   | 172   | 101.8             |

\* Нийт малд оногдуулж бодсоноор

1995 онд нэг малчин өрхөд улсын дунджаар 169 толгой мал ногдож байсан бол 1996 онд 172 толгой болов.

Архангай, Хөвсгөл, Орхон, Өвөрхангай аймгийн нэг малчин өрхөд 106-144 толгой мал ногдож байхад Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Өмнөговь, Говь-Алтай аймагт 217-467 толгой мал ногдож байна. ( Хавсралт хүснэгтийн 40-р хуудаснаас үзнэ үү. Цаашид хавсралт хүснэгтийн хуудасны дугаарыг заана )

**III. 2. Малчдын соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт.** 1996 онд нийт малчин өрхийн 9.3 хувь буюу 15.9 мянган өрх цахилгаан эх үүсгэвэрээр хангагдсаны дотор 1.9 мянган өрх салхины хөдөлгүүртэй цахилгааны эх үүсгэвэртэй байна. 1995 онд нийт малчин өрхийн 11.3 хувь буюу 19.1 мянган өрх цахилгааны эх үүсгэвэртэй байсантай харьцуулбал энэ үзүүлэлт багасчээ.

Сэлэнгэ, Дархан-Уул аймаг, Улаанбаатарын малчин өрхийн 47.3-57.8 хувь, Орхон, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Ховд, Төв, Өмнөговь, Дорнод, Дундговь, Сүхбаатар аймгийн малчин өрхийн 11.2-25.7 хувь нь цахилгаан гэрэлтэй болжээ.

Харин Архангай, Баян-Өлгий, Увс, Завхан, Өвөрхангай аймгийн малчин өрхийн 2.2-3.4 хувь нь цахилгааны эх үүсгэвэртэй байгаа нь аймгууд дотроос хамгийн доогуур түвшинд байна. ( Хавсралт хүснэгтийн 41-42 хуудас ) Салхин хөдөлгүүртэй цахилгааны эх үүсгэвэрийг Өмнөговь, Дундговь, Дорноговь, Дорнод аймгийн малчид бусад аймгуудынхаас харьцангуй илүүтэй ашиглаж байна.

1995 онд малчин өрхийн 9.9 хувь буюу 16.8 мянган өрх телевизортой байсан бол 1996 онд 9.2 хувь буюу 15.6 мянга нь телевизортой болжээ. Нийслэл хот, Орхон, Сэлэнгэ, Хэнтий, Говьсүмбэр, Ховд, Дархан-Уул аймгийн малчин өрхийн 17.2-42.8 хувь телевизортой байгаа нь бусад аймгуудаас дээгүүр үзүүлэлттэй байна.

1996 оны байдлаар нийт малчин өрхийн 71.1 хувь нь оёдлын машинтай, 62.5 хувь радио хүлээн авагчтай, 3.5 хувь автомашинтай, 14.7 хувь нь мотоциклтэй байна.

Судалгааны үзүүлэлтийн хүрээнд нэгтгэн дүгнэж үзвэл малчин өрхийн соёл, ахуй хангамжийн олонхи үзүүлэлт өмнөх 1995 оныхоос буурсан байна.

Аймгуудын дотроос Сэлэнгэ, Дорноговь, Хэнтий, Дундговь, Өмнөговь, Ховд, Төв, Говьсүмбэр аймгийн малчдын соёл, ахуйн хангамжийн үзүүлэлт бусад аймгийнхаас дээгүүр байна. ( Хавсралт хүснэгтийн 42-р хуудаснаас үзнэ үү )

#### Малчин өрхийн соёл, ахуйн хангамжийн зарим үзүүлэлт

|                             | Өрхийн тоо ( мян.) |       |       |       | 1996\1995<br>хувь | Малчин өрхийн<br>тоонд эзлэх хувь |      |
|-----------------------------|--------------------|-------|-------|-------|-------------------|-----------------------------------|------|
|                             | 1993               | 1994  | 1995  | 1996  |                   | 1995                              | 1996 |
| Цахилгаан гэрэлтэй          | 16.5               | 19.7  | 19.1  | 15.9  | 83.2              | 11.3                              | 9.3  |
| Үүнээс:Салхины хөдөлгүүртэй | ....               | ..... | 1.6   | 1.9   | 118.8             | 0.9                               | 1.1  |
| Телевизортой                | 10.6               | 10.9  | 16.8  | 15.6  | 92.9              | 9.9                               | 9.2  |
| Богино долгионы холбоотой*  | 145                | 308   | 316   | 16    | 5.1               | 0.2                               | 0.0  |
| Радио хүлээн авагчтай       | 105.2              | 114.1 | 111.3 | 106.4 | 95.6              | 65.7                              | 62.5 |
| Автомашинтай                | ....               | ..... | 4.9   | 6.0   | 122.4             | 2.9                               | 3.5  |
| Мотоциклтэй                 | ....               | ..... | 26.7  | 25.0  | 93.6              | 15.8                              | 14.7 |
| Оёдлын машинтай             | ....               | ..... | 125.6 | 120.9 | 96.3              | 74.2                              | 71.1 |

\* Өрхийн тоогоор

**III. 3. Малчин өрхийн орлого.** 1996 оны жилийн эцсийн мал тооллоготой хамтруулан малчин өрхийн хүрээнд мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогын хэмжээг тодорхойлох судалгааг нэлэнхүй байдлаар явуулав.

Судалгааны зорилго нь малчин өрхийн мал аж ахуйн бүтээгдэхүүнээс гадагш худалдан борлуулсан орлогын хэмжээг малын тоо толгойн бүлэглэлт, соёл ахуйн үзүүлэлттэй нь холбон судлах, нэг өрхийн орлогын дундаж хэмжээг сум, аймаг, улсын түвшинд тодорхойлох явдал байв. Малчин өрхийн орлогын хэмжээг тодорхойлохдоо өрхийн аж ахуйн дотоодын хэрэглээг тооцож оруулах зорилт тавиагүй болно.

Судалгааны дүнгээс үзвэл 10 хүртэл малтай малчин өрхийн жилийн дундаж орлого 60 мянган төгрөг байхад 2000-аас дээш малтай өрхийн жилийн дундаж орлого 6 сая төгрөг болж байна.

Өрхийн орлогын дүнд мал, мах борлуулсны орлого 43.9 хувь, ноос, ноолуур, хөөвөр, хялгасны орлого 26.8 хувь, арьс, ширний орлого 20.7 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүний орлого 6.2 хувийг эзлэж байна.

Мал аж ахуйгаас орсон орлогын 36.1 хувийг хонины аж ахуй, 30.6 хувийг ямааны, 20.5 хувийг үхрийн, 7.7 хувийг адууны, 2.8 хувийг тэмээний аж ахуй бүрдүүлж байна.

Малчин өрхийн орлого, орлогын бүрэлдэхүүн, 1996 оны байдлаар

|   | Борлуулалтын орлогын бүтэц<br>бүрэлдэхүүн  |                                      |
|---|--|--------------------------------------|
|   | Борлуулалтын<br>орлогын дүн<br>( сая.төг ) | Орлогын<br>бүрэлдэхүүн<br>( хувиар ) |
| <b>Орлого, бүтээгдэхүүний төрлөөр :</b> |  |                                      |
| Мал, махны борлуулалтын орлого          | 22281.6                                    | 43.9                                 |
| Сүү, сүүн бүтээгдэхүүний орлого         | 3155.9                                     | 6.2                                  |
| Ноос, ноолуур, хөөвөр, хялгасны орлого  | 13644.5                                    | 26.8                                 |
| Арьс, ширний орлого                     | 10505.2                                    | 20.7                                 |
| Бусад орлого                            | 1206.9                                     | 2.4                                  |
| <b>ДҮН</b>                              | <b>50794.1</b>                             | <b>100.0</b>                         |
| <b>Орлого, мал аж ахуйн төрлөөр</b>     |  |                                      |
| Тэмээний аж ахуйгаас                    | 1399.3                                     | 2.7                                  |
| Адууны аж ахуйгаас                      | 3916.7                                     | 7.7                                  |
| Үхрийн аж ахуйгаас                      | 10393.5                                    | 20.5                                 |
| Хонины аж ахуйгаас                      | 18352.9                                    | 36.1                                 |
| Ямааны аж ахуйгаас                      | 15524.3                                    | 30.6                                 |

Адуу, үхэр, хонь, тэмээний аж ахуйд борлуулалтын орлогын 50-75 хувийг махны үйлдвэрлэлт эзэлдэг байхад ямааны аж ахуйд ноолуурын орлого 68 хувийг эзлэж байна.



Тэмээний аж ахуйн хувьд ноосноосоо махны орлого нь давамгайлж, хонины аж ахуйд мах, арьсны орлого бүх орлогод нь зонхилох байр суурьтай болсон нь тэмээ, хонины тоо толгой буурах үндсэн шалтгаан болж байна. Гэтэл ямааны аж ахуйд нийт орлогын дөнгөж 15.6 хувийг махны орлого эзлэж, ноолуурын орлого дийлэнхийг эзлэж байгаагаас ямааны тоо толгой сүүлийн жилүүдэд жил дараалан өсч ирлээ.

Мал аж ахуйн бүтээгдэхүүний орлогын бүтэц, малын төрлөөр

|                                      | 1996             |                |                |                |                |
|--------------------------------------|------------------|----------------|----------------|----------------|----------------|
|                                      | Тэмээний аж ахуй | Адууны аж ахуй | Үхрийн аж ахуй | Хонины аж ахуй | Ямааны аж ахуй |
| Мах,махны борлуулалтын орлого        | 49.9             | 74.9           | 68.0           | 50.0           | 15.6           |
| Сүү,сүүн бүтээгдэхүүний орлого       | 2.9              | 13.8           | 20.7           | 0.9            | 1.6            |
| Ноос,ноолуур, хөөвөр,хялгасны орлого | 45.0             | 0.9            | 0.8            | 12.5           | 68.3           |
| Арьс,ширний орлого                   | 2.2              | 10.4           | 10.5           | 36.6           | 14.5           |
| Дүн                                  | 100.0            | 100.0          | 100.0          | 100.0          | 100.0          |

Малчин өрхийн аж ахуйд малын төрөл тус бүрийн орлогын хэмжээ байгалийн бүс нутгаар нэлээд ялгавартай байна. Хангай, тал хээрийн бүсийн аймгуудын өрхийн орлогод үхэр, хонь, адууны аж ахуйн бүтээгдэхүүн зонхилж байхад говь, Их нуурын хотгорын бүсийн аймгуудад ямаа, тэмээний аж ахуйн бүтээгдэхүүн голлох байрыг эзлэж байна.

Харин Их нуурын хотгорын бүсэд оруулсан аймгуудаас Баян-Өлгий, Ховд, Увс аймагт хонины аж ахуйн бүтээгдэхүүний орлого тэргүүлэх байр суурьтай, нийт орлогын 41-45 хувийг эзлэж байгаа онцлогтой юм. ( Хавсралт хуудасны дугаар 43,44 )

Малчин өрхийн орлогод голлох суурийг эзэлдэг мал аж ахуйн төрөл, бүс нутгаар, 1996 оны байдлаар ( хувиар )

| Хангай, тал хээрийн бүсийн аймаг | Адууны аж ахуйн орлого | Үхрийн аж ахуйн орлого | Хонины аж ахуйн орлого | Говь, Их нуурын хотгорын бүсийн аймаг | Тэмээний аж ахуйн орлого | Ямааны аж ахуйн орлого |
|----------------------------------|------------------------|------------------------|------------------------|---------------------------------------|--------------------------|------------------------|
| Архангай                         | 12.6                   | 30.5                   | 37.0                   | Баянхонгор                            | 2.5                      | 50.4                   |
| Булган                           | 16.2                   | 29.2                   | 33.6                   | Говь-Алтай                            | 5.7                      | 44.5                   |
| Дорнод                           | 9.0                    | 36.8                   | 39.4                   | Дорноговь                             | 7.0                      | 31.7                   |
| Завхан                           | 9.1                    | 20.0                   | 45.4                   | Дундговь                              | 3.0                      | 36.9                   |
| Өвөрхангай                       | 10.4                   | 23.9                   | 38.3                   | Өмнөговь                              | 15.5                     | 50.0                   |
| Сүхбаатар                        | 10.1                   | 31.2                   | 31.3                   | Ховд                                  | 2.9                      | 39.8                   |
| Сэлэнгэ                          | 10.2                   | 55.7                   | 23.7                   | Увс                                   | 4.2                      | 30.2                   |
| Төв                              | 14.3                   | 32.2                   | 35.8                   | Баян-Өлгий                            | 1.0                      | 27.4                   |
| Хөвсгөл                          | 6.7                    | 27.1                   | 36.6                   |                                       |                          |                        |
| Хэнтий                           | 11.2                   | 29.3                   | 28.7                   |                                       |                          |                        |

|             |      |      |      |  |  |  |
|-------------|------|------|------|--|--|--|
| Дархан-Уул  | 14.0 | 38.8 | 22.8 |  |  |  |
| Улаанбаатар | 9.2  | 57.6 | 20.2 |  |  |  |
| Орхон       | 9.7  | 31.9 | 36.4 |  |  |  |
| Говьсүмбэр  | 7.2  | 20.8 | 53.0 |  |  |  |

Манай улсын нийт малын 77.5 хувьтай тэнцэх 22.7 сая мал малчдын өмчинд хамрагдаж байна. Малчдын дотроос бизнесийн хүрээнд хамгийн жин, нөлөөтэй хэсэг нь 101-500 малтангууд буюу дундчууд юм. Энэ бүлэгт малчин өрхийн 43.9 хувь, малын 67.4 хувь, орлогын 61.4 хувь ногдож, өрхийн жилийн дундаж орлого нь 327-557 мянган төгрөг болж байна.

501-ээс дээш малтай малчид нийт малчин өрхийн 2.5 хувь, малын 12.5, орлогын 12.0 хувийг эзлэж байгаа бөгөөд дундаж орлого нь 1.3-6.0 сая төгрөгт хүрчээ. Гэтэл малчин өрхийн 53.7 хувийг эзлэж байгаа 100 хүртэл малтангууд малын 20.1 хувь, орлогын 26.5 хувийг эзлэж, тэдний жилийн орлого 60-192 мянган төгрөг байна.

#### Малчдын өрх, мал, орлогын бүлэглэлт, 1996 оны байдлаар

|                      | Өрхийн тоо    | Малын тоо (мян.тол) | Нийт орлого (сая.төг) | Дүнд эзлэх хувь |              |                  |
|----------------------|---------------|---------------------|-----------------------|-----------------|--------------|------------------|
|                      |               |                     |                       | Өрхийн тоо      | Малын Тоо    | Орлого (мян.төг) |
| 10 хүртэл малтай     | 10047         | 61.7                | 606.6                 | 5.9             | 0.3          | 1.2              |
| 11-30 малтай         | 18562         | 406.0               | 1845.9                | 10.9            | 1.8          | 3.6              |
| 31-50 малтай         | 21197         | 872.7               | 3021.7                | 12.5            | 3.8          | 6.0              |
| 51-100 малтай        | 41469         | 3215.8              | 7980.1                | 24.4            | 14.2         | 15.7             |
| 101-200 малтай       | 44950         | 6570.2              | 14699.1               | 26.4            | 28.9         | 28.9             |
| 201-500 малтай       | 29671         | 8734.8              | 16520.3               | 17.4            | 38.5         | 32.5             |
| 501-999 малтай       | 3702          | 2282.2              | 4971.1                | 2.2             | 10.0         | 9.8              |
| 1000-1499 малтай     | 444           | 496.0               | 971.1                 | 0.3             | 2.2          | 1.9              |
| 1500-2000 малтай     | 32            | 53.2                | 117.8                 | 0.0             | 0.2          | 0.2              |
| 2001-ээс дээш малтай | 10            | 23.1                | 60.4                  | 0.0             | 0.1          | 0.1              |
| <b>ДҮН</b>           | <b>170084</b> | <b>22715.7</b>      | <b>50794.1</b>        | <b>100.0</b>    | <b>100.0</b> | <b>100.0</b>     |

Судалгааны дүнгээс үзвэл 1996 онд улсын хэмжээгээр нэг малчин өрх дунджаар 4.2 ам бүлтэй, 133.6 толгой малтай, жилдээ 298.6 мянган төгрөгийн орлоготой, 11 өрх тутмын нэг нь цахилгаан гэрэл, телевизортэй, 28 өрхийн нэг нь автомашинтай, 7 өрхийн нэг нь мотоциклтэй байна.

Өрхийн малын тоо ихсэх тутам орлого нь нэмэгдэж, соёл, ахуйн хангамж дээшилж байгаа хандлага ажиглагдаж байна.

500-аас дээш малтай малчин 100 өрх тутмаас дунджаар 39-40 өрх цахилгаан гэрэл, телевизортой, 22 өрх нь автомашин, 62 нь мотоциклтэй байхад үүнээс доогуур малтай бүлгийн малчдын 100 өрх тутмын 8-9 өрх нь цахилгаан гэрэл, телевизортэй, 3 нь автомашинтай, 14 нь мотоциклтэй байна.

Малчин өрхийн мал, орлогын бүлэглэлт, соёл,  
ахуйн зарим үзүүлэлт, 1996 оны байдлаар

|                      | Нэг өрхөд дунджаар ногдох |           |                  | Өрхийн хэдэн хувь нь |                 |               |             |
|----------------------|---------------------------|-----------|------------------|----------------------|-----------------|---------------|-------------|
|                      | Ам бүлийн тоо             | Малын тоо | Орлого (мян.төг) | Цахилгаан гэрэлтэй   | Телеви – зортэй | Авто машинтай | Мотоциклтэй |
| 10 хүртэл малтай     | 3.7                       | 6.1       | 60.4             | 17.3                 | 10.9            | 1.1           | 3.0         |
| 11 - 30 “-“          | 3.6                       | 21.9      | 99.4             | 9.1                  | 7.8             | 1.0           | 4.9         |
| 31 – 50 “-“          | 3.7                       | 41.2      | 142.6            | 8.4                  | 7.4             | 1.9           | 8.5         |
| 51-100 “-“           | 3.8                       | 77.5      | 192.4            | 5.7                  | 6.5             | 2.2           | 10.3        |
| 101-200 “-“          | 4.2                       | 146.2     | 327.0            | 6.4                  | 7.8             | 3.5           | 15.1        |
| 201-500 “-“          | 5.2                       | 294.4     | 556.7            | 12.3                 | 12.5            | 6.5           | 27.9        |
| 501-999 “-“          | 6.1                       | 616.5     | 1342.8           | 40.0                 | 38.5            | 20.6          | 60.7        |
| 1000-1499“-“         | 6.6                       | 1117.2    | 2187.1           | 54.3                 | 45.9            | 29.1          | 77.5        |
| 1500-2000“-“         | 7.0                       | 1661.1    | 3680.3           | 59.4                 | 53.1            | 43.8          | 46.9        |
| 2001-ээс дээш малтай | 5.7                       | 2311.4    | 6038.6           | 40.0                 | 40.0            | 30.0          | 30.0        |
| Дүн                  | 4.2                       | 133.6     | 298.6            | 9.3                  | 9.2             | 3.5           | 14.7        |

Судалгаанаас үзэхэд малчин өрх мал аж ахуйгаасаа сард дунджаар 24.3 мянган төгрөгийн орлого олсон дүн гарч байгаа нь хөдөөгийн өрхийн аж ахуйн түүвэр судалгааны дүнтэй тохирч байгаа юм.

Өрхийн аж ахуйн судалгаагаар хөдөөгийн өрхийн зарлагын 44.1 хувийг хүнсний бүтээгдэхүүн, 47.6 хувийг хүнсний бус бүтээгдэхүүний зарлага эзэлдгийн дотор бөс, бараа, гутал, хувийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардал гуравны хоёр шахмыг нь эзэлдэг байна.

Өрхийн хувийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 80 шахам хувийг машин, мотоциклийн сэлбэг хэрэгсэл, бензин шатахууны зардал эзлэж байна.

Хөдөөгийн өрхийн хувийн үйлдвэрлэл, үйлчилгээний  
жилийн дундаж зардал, 1996 оны байдлаар

|  | Нэг өрхийн дундаж зардал ( төг ) | Зардлын бүтэц хувиар |
|--|----------------------------------|----------------------|
| Зарлага бүгд                               | 37542                            | 100.0                |
| үүнээс: Машин, мотоциклийн сэлбэг хэрэгсэл | 11654                            | 31.0                 |
| Түлш шатхуун                               | 18318                            | 48.8                 |
| Малын тэжээл                               | 3756                             | 10.0                 |
| Бусад                                      | 3814                             | 10.2                 |

Судалгаагаар говийн бүсийн аймгууд болон Ховд,Төв, Завхан зэрэг аймгуудын өрхийн дундаж орлого улсын дунджаас дээгүүр байна. Энэ нь нэгдүгээрт эдгээр аймгийн нэг өрхөд ногдох малын тоо, түүний бүрэлдэхүүнтэй, хоёрдугаарт зах зээлийн орчин нөхцөлтэй холбоотой байгаа бөгөөд энэ байдал нь тэдгээрийн соёл, ахуйд ч нөлөөлж байна.

Малчин өрхийн орлого, соёл ахуйн түвшингээр, улсын дунджаас дээгүүр байгаа аймгуудыг зэрэгцүүлж үзүүлбэл : 1996 оны байдлаар

|              | Нэг өрхийн дундаж |           | Өрхийн хэдэн хувь нь |               |               |              |
|--------------|-------------------|-----------|----------------------|---------------|---------------|--------------|
|              | Ам бүлийн Тоо     | Малын тоо | Цахилгаан гэрэлтэй   | Телевизор-Той | Авто Машинтай | Мото-циклтэй |
| Дундговь     | 497.0             | 220       | 12.6                 | 15.3          | 5.9           | 29.7         |
| Ховд         | 441.1             | 158       | 16.4                 | 17.2          | 5.7           | 16.6         |
| Говь-Алтай   | 426.0             | 193       | 7.0                  | 11.0          | 5.1           | 26.5         |
| Өмнөговь     | 401.6             | 189       | 14.7                 | 7.1           | 6.1           | 29.4         |
| Төв          | 377.5             | 128       | 14.8                 | 14.8          | 3.7           | 12.0         |
| Говьсүмбэр   | 370.2             | 160       | 25.7                 | 17.3          | 7.2           | 38.0         |
| Дорноговь    | 369.8             | 185       | 18.4                 | 16.0          | 4.7           | 26.5         |
| Завхан       | 354.6             | 162       | 3.2                  | 3.9           | 4.5           | 14.8         |
| Баянхонгор   | 332.3             | 153       | 5.0                  | 9.9           | 3.3           | 18.2         |
| Сэлэнгэ      | 321.8             | 66        | 47.3                 | 33.2          | 3.7           | 8.7          |
| Булган       | 318.5             | 129       | 5.9                  | 8.8           | 3.6           | 13.9         |
| Өвөрхангай   | 310.3             | 123       | 3.4                  | 5.5           | 1.9           | 13.4         |
| Улсын дундаж | 298.6             | 134       | 9.3                  | 9.2           | 3.5           | 14.7         |

Нийт малчин өрхийн 5.9 хувь нь 10 хүртэл малтай, 10.9 хувь нь 11-30 малтай, 12.5 хувь нь 31-50 малтай, 24.4 хувь нь 51-100 малтай, орлого багатай өрхүүд байна.

Малчин өрхийн хагасаас илүү нь ( 53.7 хувь ) болох 100 хүртэл малтай өрх мал аж ахуйн бүтээгдэхүүнээсээ жилд олсон борлуулалтын орлого улсын дунджаар 147.2 мянган төгрөг, сарынх 12.3 мянган төгрөгөөс хэтрэхгүй байна.

Судалгаанаас үзвэл Архангай, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод, Хэнтий болон Дархан-Уул, Орхон аймаг, Улаанбаатар хотод дээрх 100 хүртэл малтай өрх бусад аймгаас харьцангуй олон байгаа ажээ.

100 хүртэл малтай малчин өрхийн тоо, тэдгээрийн орлого  
байршлаар, 1996 оны байдлаар ( мян.төг )

|             | 10 хүртэл<br>малтай | 11-30<br>малтай | 31-50<br>малтай | 51-100<br>малтай | Эдгээр<br>өрхийн дүн | Нийт өрх<br>өд эзлэх<br>хувь | Жилийн<br>дундаж<br>орлого |
|-------------|---------------------|-----------------|-----------------|------------------|----------------------|------------------------------|----------------------------|
| Архангай    | 1311                | 2774            | 2918            | 4446             | 11449                | 70.6                         | 91.2                       |
| Баян-Өлгий  | 166                 | 575             | 1023            | 2740             | 4504                 | 53.2                         | 136.2                      |
| Баянхонгор  | 452                 | 1189            | 1437            | 2951             | 6029                 | 48.3                         | 161.7                      |
| Булган      | 348                 | 733             | 967             | 1735             | 3783                 | 56.5                         | 192.8                      |
| Говь-Алтай  | 58                  | 230             | 473             | 1837             | 2598                 | 28.4                         | 250.9                      |
| Дорноговь   | 83                  | 272             | 265             | 731              | 1351                 | 36.8                         | 119.9                      |
| Дорнод      | 621                 | 710             | 581             | 757              | 2669                 | 71.6                         | 126.9                      |
| Дундговь    | 48                  | 263             | 386             | 1221             | 1918                 | 26.2                         | 146.4                      |
| Завхан      | 528                 | 870             | 1214            | 2873             | 5485                 | 44.6                         | 138.7                      |
| Өвөрхангай  | 824                 | 2208            | 2547            | 4349             | 9928                 | 56.1                         | 194.6                      |
| Өмнөговь    | 47                  | 195             | 360             | 1150             | 1752                 | 28.6                         | 193.2                      |
| Сүхбаатар   | 443                 | 875             | 784             | 1473             | 3575                 | 57.6                         | 166.8                      |
| Сэлэнгэ     | 592                 | 571             | 370             | 485              | 2018                 | 81.7                         | 292.2                      |
| Төв         | 618                 | 1085            | 1233            | 2198             | 5134                 | 55.8                         | 221.8                      |
| Увс         | 540                 | 1284            | 1522            | 3145             | 6491                 | 57.8                         | 93.8                       |
| Ховд        | 196                 | 517             | 910             | 2348             | 3971                 | 41.7                         | 207.1                      |
| Хөвсгөл     | 1097                | 2209            | 2394            | 4763             | 10463                | 63.5                         | 82.8                       |
| Хэнтий      | 920                 | 1218            | 1253            | 1585             | 4976                 | 68.5                         | 124.3                      |
| Дархан-Уул  | 235                 | 199             | 120             | 149              | 703                  | 88.0                         | 49.6                       |
| Улаанбаатар | 570                 | 329             | 219             | 345              | 1463                 | 81.1                         | 149.6                      |
| Орхон       | 350                 | 244             | 191             | 152              | 937                  | 87.4                         | 101.6                      |
| Говьсүмбэр  |                     | 12              | 30              | 36               | 78                   | 32.9                         | 221.7                      |
| Дүн         | 10047               | 18562           | 21197           | 41469            | 91275                | 53.7                         | 147.2                      |

## ДҮГНЭЛТ, САНАЛ

1996 онд манай улсын мал сүргийн тоо өмнөх оныхоосоо 727.8 мянгаар өссөний дотор ямааны тоо 614.1 мянгаар нэмэгдсэнээс үзвэл малын өсөлт үндсэндээ ямааны өсөлтөөр хангагдсан болох нь тодорхой байна. Сүүлийн таван жилд ямаан сүргийн тоо жилд дунджаар 11.7 хувиар өсч байна.

Мал аж ахуйн уламжлалт хэвшлээр хонь, ямааг 3:1 буюу зуун бог тутамд 75 хонь, 25 ямааны ямааны харьцаатай өсгөн үржүүлж иржээ. Гэтэл одоо хонь, ямааны тоо 60:40 гэсэн харьцаатай боллоо.

Ямаа түргэн өсч, хонь буурч байгаа өнөөгийн байдал цаашид үргэлжилбэл дөрвөн жилийн дараа гэхэд ямааны тоо хониныхоос давж түрүүлэх төлөвтэй байна. Хэрэв энэ байдал бодит зүйл болж хувирвал улс орны эдийн засагт ямар үр дагавар үүсч болохыг одооноос туйлын анхааралтай, нухацтай авч үзэх шаардлагатай байна.

Үнэхээр бог малын хагас нь ямаа болчих юм бол хөдөө аж ахуйн мах, ноос, арьсны өнөөгийн баланс эвдэрч, бүтцийн шинжтэй өөрчлөлт гарна. Улсын хэмжээний махны нийт хэрэгцээний 43 хувийг хонины аж ахуй хангадаг. Гэтэл ямаа нь дийлэнх болчихвол махны шаардагдах хэрэгцээг хонины аж ахуй даахгүйд хүрч, хонины нэхий, ноос хүрэлцэхгүй болж, малчдын дулаан хувцас, гэрийн эсгий бүрээсний хангамж муудах үр дагаварт хүрч болох юм.

Иймд бог малын дотор хонь, ямааны бүрэлдэхүүнийг зохистой болгох үүднээс уламжлалт 3:1 гэсэн харьцааг баримтлан өсгөж үржүүлэх нь зүйтэй бөгөөд үүнийг амьдралд хэрэгжүүлэхэд татварын бодлого илүү үр нөлөөтэй байх болов уу.

Мал аж ахуй нь манай орны эдийн засгийн үндсэн салбар учраас мал тооллогыг жил бүр явуулж, малын хашаа, худгийн тооллогыг 3-5 жилд нэг удаа явуулж байх саналтай байна. Харин малчин өрхийн орлогын судалгааг мал тооллоготой хамтруулан явуулахдаа түүвэр судалгааны хүрээнд хийж болох юм.

Мал тооллогыг явуулах хугацааны талаар аймаг, нийслэл, Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны албан ёсны саналыг авч судалсны үндсэн дээр Засгийн газарт асуудлыг оруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Нийт тоологдсон малын дотроос цэвэр үүлдрийн болон эрлийз малыг ялган ангилаж бүртгэх ажил хангалтгүй хийгдэж байна. Ийм учраас мал тооллогын өмнө мал зүйч мэргэжлийн хүмүүсийг өргөн оролцуулж, үүлдрийн болон эрлийз малыг ангилан тоо толгойг нь тогтоох ажлыг Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамнаас аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газартай хамтран зориуд зохион байгуулах шаардлагатай байна.

Мал тооллогын явцад зарим тодорхой бус нутагт хяналтын тооллого, шалгалтыг улсаас зориуд зохион байгуулан явуулж байх хэрэгтэй байна.

ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН

ГАЗРЫН ДАРГА.....Ч.ДАВААСҮРЭН

1997 . 02 . 28

**Мал сүргийнхээ тоогоор улсад эхний таван байрт  
орох аймаг, сумд, 1996 оны тооллогоор**

| Аймгийн нэр               | Малын тоо<br>( мян.тол ) | Сумын нэр                  | Малын тоо<br>( мян.тол ) |
|---------------------------|--------------------------|----------------------------|--------------------------|
| <b>Нийт малын тоогоор</b> |                          |                            |                          |
| 1.Өвөрхангай              | 2550.1                   | 1.Дундговийн Эрдэнэдалай   | 285.9                    |
| 2.Завхан                  | 2474.5                   | 2.Өвөрхангайн Богд         | 232.7                    |
| 3.Баянхонгор              | 2233.1                   | 3.Өвөрхангайн Баянгол      | 208.0                    |
| 4.Говь-Алтай              | 2087.2                   | 4.Баян-Өлгийн Дэлүүн       | 206.6                    |
| 5.Хөвсгөл                 | 1976.9                   | 5.Баянхонгорын Бууцагаан   | 205.5                    |
| <b>Тэмээгээр</b>          |                          |                            |                          |
| 1.Өмнөговь                | 92.9                     | 1.Өмнөговийн Мандал-Овоо   | 13.4                     |
| 2.Баянхонгор              | 38.7                     | 2.Өмнөговийн Ханбогд       | 12.5                     |
| 3.Говь-Алтай              | 38.6                     | 3.Баянхонгорын Баянлиг     | 10.6                     |
| 4.Дорноговь               | 30.0                     | 4.Өмнөговийн Гурвантэс     | 8.8                      |
| 5.Дундговь                | 29.7                     | 5.Дундговийн Өлзийт        | 8.1                      |
| <b>Адуугаар</b>           |                          |                            |                          |
| 1.Төв                     | 261.6                    | 1.Дундговийн Эрдэнэдалай   | 30.6                     |
| 2.Өвөрхангай              | 250.7                    | 2.Булганы Сайхан           | 25.8                     |
| 3.Архангай                | 239.8                    | 3.Өвөрхангайн Баян-Өндөр   | 23.4                     |
| 4.Хөвсгөл                 | 217.7                    | 4.Хөвсгөлийн Цагаан - Уул  | 22.6                     |
| 5.Завхан                  | 200.4                    | 5.Хөвсгөлийн Цэцэрлэг      | 22.6                     |
| <b>Үхрээр</b>             |                          |                            |                          |
| 1.Хөвсгөл                 | 415.5                    | 1.Өвөрхангайн Уянга        | 42.6                     |
| 2.Архангай                | 369.4                    | 2.Архангайн Тариат         | 35.1                     |
| 3.Завхан                  | 275.3                    | 3.Завханы Их-Уул           | 32.8                     |
| 4.Өвөрхангай              | 268.2                    | 4.Хөвсгөлийн Цагаан-Уул    | 31.1                     |
| 5.Төв                     | 235.5                    | 5.Хөвсгөлийн Цэцэрлэг      | 29.4                     |
| <b>Хониор</b>             |                          |                            |                          |
| 1.Завхан                  | 1320.8                   | 1.Дундговийн Эрдэнэдалай   | 141.7                    |
| 2.Өвөрхангай              | 1260.1                   | 2.Өвөрхангайн Баянгол      | 125.2                    |
| 3.Төв                     | 1020.3                   | 3.Гвь-Алтайн Тонхил        | 100.5                    |
| 4.Увс                     | 920.7                    | 4.Өвөрхангайн Сант         | 97.2                     |
| 5.Говь-Алтай              | 909.6                    | 5.Баян-Өлгийн Дэлүүн       | 97.1                     |
| <b>Ямаагаар</b>           |                          |                            |                          |
| 1.Баянхонгор              | 1053.5                   | 1.Өвөрхангайн Богд         | 140.0                    |
| 2.Говь-Алтай              | 935.5                    | 2.Баянхонгорийн Бууцагаан  | 117.6                    |
| 3.Ховд                    | 788.8                    | 3.Өмнөговийн Гурвантэс     | 106.6                    |
| 4.Өвөрхангай              | 751.5                    | 4.Баянхонгорийн Баянцагаан | 99.0                     |
| 5.Өмнөговь                | 739.5                    | 5.Баянхонгорийн Баацагаан  | 97.0                     |

**Олон малтай малчин өрхийн тоо, аймаг, нийслэлээр.  
1996 оны байдлаар**

|             | Нийт малаар      |                  |                    | Тэмээгээр              | Адуугаар              | Үхрээр             | Хониор              | Ямаагаар             |
|-------------|------------------|------------------|--------------------|------------------------|-----------------------|--------------------|---------------------|----------------------|
|             | 1000-2000 малтай | 2001-3000 малтай | 3000-с дээш малтай | 200-гаас дээш тэмээтэй | 300-гаас дээш адуутай | 250-с дээш үхэртэй | 1000-с дээш хоньтой | 800-аас дээш ямаатай |
| Архангай    | 24               | 1                | -                  | -                      | 1                     | -                  | 3                   | -                    |
| Баян-Өлгий  | 5                | -                | -                  | -                      | -                     | 1                  | -                   | -                    |
| Баянхонгор  | 45               | -                | 1                  | 1                      | 1                     | 2                  | 3                   | 6                    |
| Булган      | 32               | 2                | -                  | -                      | 1                     | -                  | 4                   | -                    |
| Говь-Алтай  | 40               | 1                | -                  | 1                      | -                     | -                  | 1                   | 1                    |
| Дорноговь   | 11               | -                | -                  | -                      | -                     | 1                  | -                   | -                    |
| Дорнод      | 14               | -                | -                  | -                      | -                     | -                  | 1                   | -                    |
| Дундговь    | 48               | -                | -                  | 1                      | -                     | -                  | -                   | -                    |
| Завхан      | 57               | 2                | -                  | -                      | 1                     | -                  | 6                   | 1                    |
| Өвөрхангай  | 32               | -                | -                  | -                      | 2                     | 3                  | 3                   | 1                    |
| Өмнөговь    | 18               | -                | -                  | 1                      | -                     | -                  | -                   | 1                    |
| Сүхбаатар   | 20               | -                | -                  | -                      | 1                     | -                  | 4                   | -                    |
| Сэлэнгэ     | 6                | -                | -                  | -                      | -                     | -                  | 2                   | -                    |
| Төв         | 34               | 1                | 1                  | -                      | 6                     | 1                  | 6                   | -                    |
| Увс         | 17               | -                | -                  | -                      | -                     | -                  | 1                   | -                    |
| Ховд        | 32               | -                | -                  | -                      | -                     | 2                  | 4                   | 1                    |
| Хөвсгөл     | 13               | -                | -                  | -                      | -                     | 1                  | -                   | 1                    |
| Хэнтий      | 22               | 1                | -                  | -                      | 1                     | 2                  | 1                   | -                    |
| Дархан-Уул  | 1                | -                | -                  | -                      | -                     | -                  | -                   | -                    |
| Улаанбаатар | 2                | -                | -                  | -                      | -                     | -                  | -                   | -                    |
| Орхон       | 1                | -                | -                  | -                      | -                     | -                  | -                   | -                    |
| Говьсүмбэр  | 3                | -                | -                  | -                      | -                     | -                  | -                   | -                    |
| <b>ДҮН</b>  | <b>477</b>       | <b>8</b>         | <b>2</b>           | <b>4</b>               | <b>14</b>             | <b>13</b>          | <b>39</b>           | <b>12</b>            |